



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

**ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ОРОЛЦООГ ХЭРХЭН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

2020

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ОРОЛЦООГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ¹²⁰

УДИРТГАЛ

Авлигатай тэмцэх газар нь Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1.7-д “авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих” зорилт, АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.7.1-д “Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих” үйл ажиллагааны хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийхээр зорьсон.

Энэхүү ажлын хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн нь иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны талаар зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг түүвэрлэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлон, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хэрэгжүүлсэн ажлын талаарх тайлан мэдээ, нотлох баримтад тулгуурлан үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйл, 51 дүгээр зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал”, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэнэ.

Судалгааг баримт бичиг судлах, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, статистик судалгаа авах, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага авах зэрэг аргыг хэрэглэж, хараат бус бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан, үнэлгээг бодит мэдээлэлд тулгуурлан, дүгнэлтийг зөвхөн үнэлгээгээр тогтоогдсон үр дүнд үндэслэн гаргах зарчмыг баримтална.

Ийнхүү олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлох, оролцоог хэрэгжүүлсэн ажлын талаарх тайлан мэдээ, нотлох баримтыг шинжлэх, эрх зүйн зохицуулалтын үр дагавар, хэрэгжилтийг үнэлэн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн тухай дүгнэлт гаргахад чиглэх бөгөөд авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих үйл ажиллагааны хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн тухай дүгнэлт гаргахад чиглэх бөгөөд авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих үйл ажиллагаанд хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэн, боломжит хувилбарыг дэвшүүлэх юм.

НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛОХ

Авлигатай тэмцэх газраас Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1.7-д “авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих” заалтыг

¹²⁰ Энэхүү хяналт шинжилгээ, үнэлгээг АТГ-ын захиалгаар 2020 онд ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, Б.Ариунжаргал, О.Төрболд, Ерөнхий нягтлан бодогч Д.Дэлгэрмаа нар хамтран гүйцэтгэв.

энэхүү судалгааны үндэслэл болгосон тул Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу үндсэн зорилгыг тодорхойлон авч үзлээ.

Харин энэхүү зорилгод хүрэх дэд зорилгыг олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.7.1-д “Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих” гэж тодорхойлсон зарим хэсгийн хүрэх үр дүн “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийснээр гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхэд чиглэж байна.

ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОРИЛГОД ХҮРЧ БАЙГАА БАЙДАЛ

Авлигатай тэмцэх, хүний эрхийг хамгаалах нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд ерөнхий утгаараа “авлигатай тэмцэнэ гэдэг нь хүний эрх зөрчигдөхөөс хамгаалж буй хэрэг мөн”¹²¹ бөгөөд үүнд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог хуулийн дагуу нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих нь ардчилсан нийгмийн үндсэн шаардлагыг хангасан зүй зохистой үйл ажиллагаа, Үндсэн хуулиараа тунхагласан хүний эрхийг төрөөс баталгаатай хангуулах суурь болох юм.

Ийнхүү Улсын Их Хурлаас баталсан үндсэн зорилгыг хэрэгжүүлэх дэд зорилгод хүрэх үр дүнг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлсэн талаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан үнэлэх бөгөөд өнөөгийн нөхцөл байдалд шууд бусаар нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох юм.

2.1. Үнэлгээ хийх шалтгаан

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3 дугаар зүйлийн 3.2.4 дэх заалт “нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан”, 3.2.5 дахь заалт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ биелүүлэхгүй байгаа буюу Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа бол” гэсэн нөхцөлийг хангаж байгаа тул үнэлгээг гүйцэтгэх боломжтой байна.

2.2. Үнэлгээ хийх хүрээ

Судалгааны хүрээг захиалагчаас ирүүлсэн саналын дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагын хяналт, оролцоог хэрхэн хэрэгжүүлж буй байдлыг сонгож дараах байдлаар үнэлгээний хүрээг тогтоов.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжид хамрагдах өрх иргэнд үзүүлж буй үйлчилгээний төрөл, хэлбэр: Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хяналт,

¹²¹ Авлигатай тэмцэх /хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт/ (2016-2018) Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргалын илтгэлийн хэсгээс. УБ., 2019 он /8 дахь тал/

оролцоо: Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 8, 24 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг

2.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үнэлгээний ажлын хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход дараах шалгуур үзүүлэлтээс тохиромжтойг тогтооно.

- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
- Практикт нийцэж байгаа байдал;

Нийгмийн халамжийн тухай хуулийн заалтад тохируулан оновчтой, бодитой, хэмжиж болохуйц тодорхой шалгуур үзүүлэлтийг сонгон авч үнэлэх юм.

2.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрээс сонгоно.

Хүснэгт 1

№	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1.	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2.	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
4.	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

Судалгааны явцад хууль тогтоомжоос сонгон авсан зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийг байх ёстой буюу бүрэн хэрэгжсэн тохиолдолд хэрхэн авч үзэх тухай харьцуулалтын хэлбэрийг ашиглав.

2.5. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг томьёолох

“Шалгуур үзүүлэлтийг томьёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавихыг хэлэх бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалт тус бүр дээр “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэсэн асуулт тавьж үнэлгээг хийсэн.

2.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсон ба үүнээс дараахь хоёр аргыг сонгон, үнэлгээ хийх мэдээллийг цуглуулав. Үүнд:

- 1/байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
- 2/холбогдох субъектээс судалгаа авах.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Нийгмийн халамжийн багц хууль, холбогдох эрх зүйн актууд, судалгааны тайлан, ажлын тайлан, мэдээг цуглуулж, судалгаа хийхэд ашиглав.

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг авч хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, хууль эрх зүйн орчныг судлах зорилгоор практикт ажиллаж буй энэ чиглэлийн мэргэжилтэн, төрийн бус байгууллага, үйлчилгээ авч буй иргэн, бусад холбогдох хүмүүстэй уулзаж ярилцлага хийсэн. Мөн холбогдох байгууллагаас үйл

ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч судалгаа хийхэд ашиглав.

ГУРАВ. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 4.1-д мэдээлэл цуглуулах аргын дагуу холбогдох мэдээллийг цуглуулах, судалгаа хийх ажлыг хэрэгжүүлэх үе шатанд гүйцэтгэнэ. Иймд цуглуулсан мэдээллийг Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаарх ойлголт, эрх зүйн зохицуулалт, төсөв санхүүжилт гэж ангилан дараах байдлаар авч үзлээ.

3.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Нийгмийн халамж (social welfare) нь хүн амын сайн сайхан байдлыг бий болгох, тэдний суурь хэрэгцээг хангахад чиглэсэн Засгийн газар, холбогдох бусад институтийн үйл ажиллагааг илэрхийлж, юуны урьд хүн амын эдийн засаг, санхүүгийн сайн сайхан байдлыг хангах бодлого үйл ажиллагаатай холбогддог¹²² хэмээн олон улсад авч үздэг байна. Харин манай улсын Нийгмийн халамжийн тухай хуульд “нийгмийн халамж” гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгох тухай заажээ.

Энэ үүднээс нийгмийн халамжийн тогтолцоог үр дүнтэй хөгжүүлэхэд халамжийн үйлчилгээний асуудал юунаас ч илүү чухал гэж үзэж байна. Халамжийн үйлчилгээнд хамрагдах эрх, иргэнээ зөв тодорхойлж чадаагүйгээс “хавтгайрсан халамж”, “халамж эзэндээ хүрдэггүй”, “ядуу иргэн, гэр бүлийн тоо ихсэж байна” гэсэн шүүмжлэлд байнга өртөж ирсэн бөгөөд 2019 онд дэлхийн 189 орноос хүний хөгжлийн индексээр 92, аз жаргалын индексээрээ 156 орноос 83 дугаар байранд жагсав. Тэгвэл хүний хөгжлийн индексээр хүний эрүүл саруул амьдрах, суурь хэрэгцээ хангагдах эрх хамаардаг бол аз жаргалын индексээр улс үндэстнүүд өөрийн орны ард иргэдийг сайн сайхан амьдрахад хэрхэн тусалж сайн зүйл хийж байгааг харуулдаг байна. Ийнхүү иргэдийн сайн сайхан амьдрал, эрүүл саруул байх, хүний наад захын суурь хэрэгцээг хангах боломж бүрдүүлсэн улс орны иргэд аз жаргалтай, хүний хөгжлөөр тэргүүлэх нь ойлгомжтой билээ.

Улс орны халамж, хамгааллын бодлого нийгмийн эмзэг хэсгийн суурь хэрэгцээг хангах, тохиолдсон хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг¹²³ бол үүнийг төр дангаар хэрэгжүүлэхээс илүүтэй олон нийтийн оролцоог хангах байдлаар хэрэгжүүлэх нь хавтгайрсан төсвийн зарцуулалтыг багасгах ач холбогдолтой төдийгүй иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэн төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх, үйл ажиллагаанд нь чиглүүлэх төдийгүй сайн үйлсэд хандуулах ач холбогдолтой.

Нийгмийн халамжийн тухай хуульд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ болон ОНОТХҮ гэх 2 төрлийн халамжийн үйлчилгээг тусгасан байна. Тодруулбал, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэдэгт асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд буйгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэн, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг

¹²² Удирдахуйн онол практикийн асуудлууд. Эрдэм шинжилгээний бичиг №9, Доктор (Ph.D) Л.Отгонтуяа “Нийгмийн халамжийн бодлогын үр нөлөө” сэдэвт судалгааны зарим үр дүн. Уб.,2009 он. /15 дахь тал/

¹²³ Удирдахуйн онол практикийн асуудлууд. Эрдэм шинжилгээний бичиг №9, Доктор (Ph.D) Л.Отгонтуяа “Нийгмийн халамжийн бодлогын үр нөлөө” сэдэвт судалгааны зарим үр дүн. Уб.,2009 он. /15 дахь тал/

бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг¹²⁴ ойлгодог байна.

Харин ОНОТХҮ нь иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг тусалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгох бөгөөд эмзэг бүлгийн зорилтот хүн амд шууд хүрдэг нийгмийн халамжийн тогтолцооны цогц үйлчилгээ юм.¹²⁵

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ нь байнгын удаан хугацаагаар байж болдог бол ОНОТХҮ нь түр зуурын хугацаанд тусалцаа үзүүлэх үйлчилгээ явуулдаг байдлаар өөр хоорондоо ялгаатай байна. Тухайлбал: “Зөв амьдрах ухаан” ТББ нь “түр байрлуулан асрамжлах” үйлчилгээ эрхлэх эрх авсан бөгөөд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ эрхлэх эрхгүйгээр удаан хугацаагаар байрлуулж байгаа нь зөвшөөрөлгүй үйлчилгээ явуулсан гэж үзжээ.

Н.Мандуул: “Зөв амьдрах ухаан” ТББ-д хүүхдийг 24 цагаар асарч, хамгаалах зөвшөөрөл байхгүй.¹²⁶ Нийслэлийн ЗДТГ: “Зөв амьдрах ухаан” ТББ нь орон гэргүй, орц, траншейнд амьдардаг, архи мансууруулах бодист донтсон, засан хүмүүжүүлэх ангиас суллагдсан, өнчин ядуу бүх насны иргэдийг дахин нийгэмшүүлэх, ажил хөдөлмөр эхлүүлэх, сэтгэлзүйн сургалт олгож, нийгэмд эзлэх байр сууриа дахин олоход нь тусалж, бүтээлч иргэн болгон ажлын байраар хангаж, хамтдаа ажиллаж хөдөлмөрлөх боломжийг олгодог байгууллага аж¹²⁷

Төрөөс нийгмийн халамжийн үйлчилгээг нийгмийн эмзэг хэсгийн суурь хэрэгцээг хангах, тохиолдсон хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлдэг бол энэ үйлчилгээг үзүүлж байгаа байгууллагын санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээ авч буй иргэдийн санхүү, хүнсний талон, эм тарианы мөнгө, түлээ нүүрсний мөнгө, түр байрлуулах, сургалт явуулах зэрэг 70 гаруй чиглэлийн халамжийг төрөөс үзүүлдэг байна. Үүнээс ОНОТХҮ-нд 9 чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг байна.

3.1.1. Улсын хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо

Хүснэгт 2. 2018, 2019 онд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо / үйлчилгээний төрлөөр/

№	Үйлчилгээний төрөл	2018 он	2019 он
		Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хүний тоо
1	Сургалт зохион байгуулах	4487	3923
2	Зөвлөгөө өгөх	561	889
3	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	5921	3249
4	Түр байршуулан асрамжлах	250	95
5	Өдрийн үйлчилгээнд хамруулах	5494	4520
6	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	308	252
7	Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ	1000	172
8	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	960	955
9	Төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ	2239	1239
	НИЙТ ДҮН	21220	15294

¹²⁴ Нийгмийн халамжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, № 8, 2012.

¹²⁵ Олон_нийтийн_оролцоонд_түшиглэсэн_халамжийн_үйлчилгээ_2017.pdf судалгаа /нөлөөллийн шинжилгээ/ <http://rilsp.gov.mn/tasudalгаа.php?count=50> сүүлд үзсэн 2020.5.25


¹²⁶ <https://medee.mn/single/147218> сүүлд үзсэн 2020.5.25

¹²⁷ Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан <https://updown.mn/104555.html> Сүүлд үзсэн 2020.5.25

Дээрх хүснэгтэд Нийгмийн халамжийн тухай хуульд заасан 10 төрлийн үйлчилгээнээс 9 төрлийн үйлчилгээг тусгасан байгаа нь хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.10-т заасан “гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ”-г дээрх хүснэгтэд дурдаагүй нь хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4-т заасан “түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах” гэсэн өргөн утгаар зохицуулсан ойлголттой давхардсантай холбоотой юм.


2018 онд Монгол Улсын хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан 21220 хүн дээрх хүснэгтэд харагдаж буй 9 төрлийн үйлчилгээнд хамрагдсан байна. Тус үйлчилгээний төрөлд хамрагдсан иргэдийн тоог хувьчилж үзүүлбэл:

График. 2018 онд улсын хэмжээнд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо /хувь, үйлчилгээний төрлөөр/



2018 оны хувьд хуульд заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнээс сэргээн засах үйлчилгээнд хамгийн олон хүн хамрагдсан нь нийт иргэдийн 27.9 хувийг эзэлж байна. Дээрх графикаас харвал иргэд сэргээн засах, өдрийн үйлчилгээ, сүргэлт зохион байгуулах, төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд түгээмэл байдлаар хамрагддаг байна. Харин түр байршуулан асрамжлах, гэрийн асрамж халамжийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагддаг иргэдийн тоо бага байдаг байна.

График. 2019 онд улсын хэмжээнд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо /хувь, үйлчилгээний төрлөөр/



2019 оны хувьд хуульд заасан ОНОТХҮ-нээс сургалт зохион байгуулах үйлчилгээнд хамгийн олон хүн хамрагдсан байна. Энэ нь ОНОТХҮ-нд хамрагдсан нийт иргэдийн 25.7 хувийг эзэлж байна. Дээрх графикаас харвал 2019 онд иргэд сургалт зохион байгуулах, сэргээн засах, өдрийн үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд түгээмэл байдлаар хамрагдсан байна.

Дээрх хоёр графикаас үзвэл, иргэд сэргээн засах, сургалтад хамрагдах, өдрийн үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд ихэвчлэн хамрагддаг байна. Харин түр байршуулан асрамжлах, гэрийн асрамж халамжийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагддаг иргэдийн тоо бага байна.

Монгол Улсын хэмжээнд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоог авч үзвэл дараах байдлаар үйлчилгээнд хамрагдсан байна.

Хүснэгт 3. 2018, 2019 онд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо

№	Аймгийн нэр	2018 онд хамрагдсан хүний тоо	2019 онд хамрагдсан хүний тоо
1.	Архангай	264	266
2.	Баян-Өлгий	226	138
3.	Баянхонгор	927	769
4.	Булган	48	106
5.	Говь-Алтай	319	204
6.	Говьсүмбэр	109	121
7.	Дархан-Уул	208	179
8.	Дорноговь	368	49
9.	Дорнод	1262	394
10.	Дундговь	242	235
11.	Завхан	822	362
12.	Орхон	378	451
13.	Өвөрхангай	2926	917
14.	Өмнөговь	68	204
15.	Сүхбаатар	282	393
16.	Сэлэнгэ	230	1904
17.	Төв	130	127
18.	Увс	3422	543
19.	Ховд	89	172
20.	Хөвсгөл	3169	1363
21.	Хэнтий	141	120
22.	Улаанбаатар	5590	6277
	Улсын дүн	21220	15294

ОНОТХҮ-нд 2018 онд нийт 21220 хүн хамрагдсан байна. Нийт энэхүү үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 26.3 хувийг Улаанбаатар хотод амьдардаг иргэд эзэлж байна.

Хөдөө орон нутгийн хувьд хамгийн их нь Увс аймагт 3422 иргэн энэ төрлийн үйлчилгээнд хамрагдсан бөгөөд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн 16.1 хувийг эзэлж байна. Мөн Хөвсгөл аймагт 3169 буюу 14.9 хувь, Өвөрхангай аймагт 2926 ОНОТХҮ-нд хамрагдсан нийт тус үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 13.8 хувийг тус тус эзэлж байна. Хөдөө орон нутгаас энэ төрлийн үйлчилгээнд хамгийн бага хүн хамрагдсан аймаг нь 2018 оны хувьд Булган аймаг 48 буюу 0.2 хувьтай байна.

ОНОТХҮ-нд 2019 оны хувьд нийт 15294 хүн хамрагдсан нь өмнөх оныхтой харьцуулахад 5926-аар буурсан байна.

2019 онд нийт энэхүү үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 41 хувийг Улаанбаатар хотод амьдардаг иргэд эзэлж байна. Хөдөө орон нутгийн хувьд хамгийн их нь Сэлэнгэ аймагт 1904 иргэн энэ төрлийн үйлчилгээнд хамрагдсан нь нийт ОНОТХҮ-

нд хамрагдсан иргэдийн 12.4 хувийг эзэлж байна. Мөн Хөвсгөл аймаг 1363 буюу 8.9 хувь, Өвөрхангай аймагт 917 хүн ОНОТХҮ-нд хамрагдсан нийт иргэдийн 6 хувийг тус тус эзэлж байна.

Хөдөө орон нутгаас энэ төрлийн үйлчилгээнд хамгийн бага хүн хамрагдсан аймаг нь 2019 оны хувьд Дорноговь аймаг 49 буюу 0.2 хувийг эзэлж байна.

Дээрхээс дүгнэвэл, 2018 онд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо 2019 оныхтой харьцуулахад 5926-аар их байна. Түүнчлэн, нийт энэ төрлийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн олонх нь Улаанбаатар хотод оршин суудаг байна.

2018, 2019 онд тус үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоог аймаг тус бүрээс авч үзэхэд 2018 оны хувьд Увс, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудад ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо их байсан бол 2019 онд Увс, Хөвсгөл аймагт энэ төрлийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өмнөх оныхтой харьцуулахад огцом буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2018 онд Увс аймаг энэ төрлийн үйлчилгээнд нийт 3422 хүн хамрагдаж байсан бол 2019 онд 543 болж 2879 хүнээр буурсан үзүүлэлттэй байна.

Тус үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2019 онд өмнөх оныхтой харьцуулахад буурсан. Харин Архангай, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Улаанбаатар хотод тус үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өмнөх оныхтой харьцуулахад тодорхой хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.1.2. Нийслэлийн хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо

Хүснэгт 4. Нийслэлийн хэмжээнд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо

№	Үйлчилгээний төрөл	2018 он	2019 он
		Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хүний тоо
1	Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах	1151	1725
2	Зөвлөгөө өгөх	172	572
3	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	2018	1555
4	Түр байршуулан асрамжлах	28	34
5	Өдрийн үйлчилгээнд хамруулах	797	803
6	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	194	121
7	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	758	842
8	Төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ	670	625
Нийт дүн		5788	6277

Судалгааны ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2018, 2019 онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, санхүүжилтийн талаарх тайлан мэдээг авсан. Гэсэн хэдий ч тус байгууллагаас ирүүлсэн тоон мэдээ нь өөр хоорондоо зөрүүтэй байна. Дээрх хүснэгтэд 2018 онд нийслэлийн хэмжээнд нийт 5788 хүн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан гэсэн тоон мэдээ байна.

Гэтэл “**Хүснэгт 2.** 2018, 2019 онд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо”, “**Хүснэгт 3.** 2018, 2019 онд ОНОТХҮ-нд хамрагдсан иргэдийн тоо /үйлчилгээний төрлөөр/” мэдээг тус байгууллагаас ирүүлсэн тоон мэдээнд үндэслэн хүснэгтэлсэн боловч 2018 онд нийслэлийн хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 5590 гэж тус байгууллагаас ирүүлсэн тайланд тусгасан байна.

"Зөв амьдрах ухаан" ТББ нь 0-70 насны 120 гаруй иргэний сар бүр олгогдох бүтэн өнчин хүүхдийг асарч буй иргэний тэтгэмж, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асарч буй иргэний тэтгэмж зэрэг Г.Загдаагийн эхнэр Г.Амарсайханы дансаар нийт 554.000 төгрөг оржээ. Мөн түр хоноглуулах үйлчилгээнд хамрагдсан нийт 33 иргэдийн халамжийн тэтгэвэр, хүүхдийн мөнгө, цалинтай ээжийн мөнгө, насны хишиг, түр хоноглохын үнэ гэх мэт 2019 оны сүүлийн 11,12 дугаар сард 19 сая 820 мянган төгрөгийг авсан бол 2018 онд 400 сая, 2019 онд 240 сая төгрөгийг тус тус улсын төсвөөс шилжүүлснийг зорилтод бүлгийн иргэдэд хүргэдэггүй дэргэдээ авч хооллож, орон гэртэй байлгадаг гэх нэрийн дор өөртөө үлдээдэг болох нь тогтоогдсон байна.¹²⁸

Мөн ямар нэгэн өвчин зовлонгүй, гэр бүлийн хувьд асуудалгүй, ажил хөдөлмөр хийгээд явах боломжтой иргэд халамжийн үйлчилгээнд хамрагдах сонирхол ихсэж худал бичиг баримт бүрдүүлдэг байна.

Олон хүүхэдтэй нөхрөөсөө салсан гэж бичиг баримт бүрдүүлэн халамжид хамрагдсан байдаг, залуучууд халамжийн үйлчилгээнд хамрагдах сонирхолтой болсон.¹²⁹

Энэ мэтчилэн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, үйлчилгээ авах сонирхолтой иргэдэд төрийн бодлого, хяналтыг нэмэгдүүлэх, иргэд олон нийтийн тусламж үзүүлэх оролцоог дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, түр байрлуулан асрамжлах үйлчилгээг цэгцлэх хууль хоорондын уялдаа холбоог хангах шаардлага үүсээд байна.

Халамж, хамгааллын бодлого нийгмийн эмзэг хэсгийн суурь хэрэгцээг хангах, тохиолдсон хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд төр дангаар оролцохоос илүүтэй олон нийтийн оролцоог хангасан бодлого шийдвэрийг гарган түүндээ сөрөг хандлага буюу эмзэг байдлыг далимдуулан туслах нэртэй хүний эрхэнд халдах байдлаас хамгаалах шийдвэрийг гарган хэрэгжүүлэх нь төсөв болон үйл ажиллагааг хөнгөлөх, хөгжлийг хурдасгах ач холбогдолтой хэмээн бусад улс орон хэрэгжүүлдэг байна.

Тухайлбал, Англи улсад 2011 оноос олон нийтийн оролцоотой халамжийн үйл ажиллагаанд хувийн болон төрийн зүгээс тэнцвэртэй байдлыг хадгалж буй нь хөгжлийг хурдасгах явдал хэмээн үзсэн байна.¹³⁰ АНУ-д олон нийтийн халамжийн түүх нь улс орны байнгын өсөлт, хөгжлийн нэг мөн бөгөөд 1900 оноос орон нутгийн Засгийн газар хувийн буяны байгууллагатай хамт олон нийтийн туслалцаа "нийтийн тусламж" үзүүлэх томоохон үүрэг хүлээдэг¹³¹ байсан. Харин сүүлийн үед олон нийтийн тусламж үйлчилгээг гутаан доромжлол гэж үздэг болсон бөгөөд хамрагдахаас аль болох зайлсхийдэг байна.¹³² Австралийн Засгийн газраас албан бус үйлчилгээ нь албан ёсны халамжийн үйлчилгээ үзүүлэх бөгөөд албан бус үйлчилгээ нь бусад албан ёсны дэмжлэг үзүүлэх үйлчилгээний эрэлтийг бууруулдаг¹³³ гэж үзжээ.

3.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаарх эрх зүйн зохицуулалт

Манай улсад Нийгмийн халамжийн багц хууль анх 1995 онд батлагдсанаар нийгмийн зүгээс зайлшгүй дэмжлэг туслалцаа үзүүлбэл зохих бие даан амьдрах, өөртөө үйлчлэх чадваргүй эмзэг бүлгийн иргэдийг төр ивээлдээ авч, тэдний амьдралын баталгааг алдагдуулахгүй байх зорилготой нийгмийн халамжийн тогтолцоо бий болсон. Үүнээс хойш Нийгмийн халамжийн хуулийг 1998, 2005, 2012

¹²⁸ Г.Загдаа эмзэг бүлгийн иргэдийн 600 гаруй саяыг завшжээ. <https://www.urug.mn/news/1048>

¹²⁹ БЗД-ийн хяналтын албаны мэргэжилтэн Ч.Гүндсамбуу /ярилцлагын хэсгээс/

¹³⁰ Public and Private Welfare Activity in England <http://sticerd.lse.ac.uk/dps/case/cp/casepaper193.pdf> June 2016

¹³¹ Origins of the State and Federal Public Welfare Programs By John E. Hansan, Ph.D.

<https://socialwelfare.library.vcu.edu/public-welfare/origins-of-the-state-federal-public-welfare-programs/>

¹³² How to improve participation in social assistance programs <https://wol.iza.org/uploads/articles/104/pdfs/how-to-improve-participation-in-social-assistance-programs.pdf>

¹³³ Understanding welfare and wellbeing <https://www.aihw.gov.au/reports/australias-welfare/understanding-welfare-and-wellbeing> Release Date: 11 Sep 2019

онд шинэчлэн найруулж, 2000, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж байжээ.¹³⁴

2005 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуульд анх удаа олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуульчлан өгснөөр нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийн нэн тэргүүний хэрэгцээнд үндэслэсэн нийгмийн халамжийн шинэ үйлчилгээ болон хэрэгжиж эхэлсэн.

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2012 оны 1 сарын 19-ний өдөр батлагдан, 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх болсон бөгөөд энэхүү хуулиар олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ нь иргэн, аж ахуйн нэгж (ААН), төрийн бус байгууллага (ТББ)-ын оролцоотойгоор 12 бүлгийн өрх, иргэнд арван төрлийн дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг тусгаж өгсөн байна.

Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр нийт 10180¹³⁵ эрх зүйн акт байгаагаас олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд чиглэсэн харилцааг зохицуулан үйлчилж буй дараах хууль тогтоомж байна.

- Хууль 32
- Улсын Их Хурлын тогтоол 5
- Засгийн газрын тогтоол 9
- Сайдын тушаал 7
- Бусад эрх зүйн акт үйлчилж байна. (хавсралт 1)

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ гэж иргэн, аж ахуйн нэгж төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг¹³⁶ хэлэх бөгөөд Монгол Улсын нийгмийн халамжийн хуулиудад үйлчилгээний төрөл, хяналт, оролцоог дараах байдлаар тусгаж хэрэгжүүлж ирсэн байна. Тодруулбал:

Анх 2005 оны Нийгмийн халамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлд¹³⁷ Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд:

- Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;
- Зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах;
- Сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- Түр байрлуулан асрамжлах;
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах зэрэг 5-н төрлийн үйлчилгээг тусгасан байна.

Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамж үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагын үйл ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, нөхцөлт мөнгөн тэтгэмж, мөнгөн тусламж болон нийгмийн халамжийн зориулалттай хөрөнгийн, зээлийн, хандивын зарцуулалтад хяналт тавих, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах саналаа энэ хуулийн 6.8-д заасан байгууллагад тавих чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байж болно”, 6.10 дахь хэсэгт “Аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага хяналт,

¹³⁴ Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл <http://mlsp.gov.mn/nnews/431> сүүлд үзсэн 2020.5.25

¹³⁵ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем дэх эрх зүйн акт. <http://legalinfo.mn/> сүүлд үзсэн 2020.5.25.

¹³⁶ Нийгмийн халамжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №, (2012)

¹³⁷ Нийгмийн халамжийн тухай хууль /2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/, (2005)

шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан ажилтантай байж болно”, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт Нийгмийн ажилтан дор дурдсан эрх эдэлнэ хэмээн 10.4.1 дэх заалтад “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх байгууллага, иргэнийг сонгоход оролцох, үйл ажиллагаа, үйлчилгээнийх нь чанарт хяналт, үнэлгээ хийх;” гэх зэргээр хяналтын тогтолцоог хэн хэрхэн хэрэгжүүлэх талаар заасан байна.

Үүнээс үзвэл 2005 оны хуульд Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нэгжтэй байж болно хэмээн эрх олгосон зохицуулалт оруулан анхан шатны хяналтыг нийгмийн ажилтан хэрэгжүүлэхээр заасан нь харагдаж байна.

Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нийгмийн халамжийн тухай хуульд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 10 төрөл болгон өргөжүүлэн хуульчилсан байна. Үүнд:

1. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;
2. Зөвлөгөө өгөх;
3. Сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
4. Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;
5. Өдрийн үйлчилгээнд хамруулах;
6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
7. Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
8. Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
9. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах;
10. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах зэрэг үйлчилгээг тухайн аймаг, дүүргийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн ААН, ТББ-аар гүйцэтгүүлдэг бөгөөд нийгмийн халамжийн хяналтын мэргэжилтнүүдээс үйлчилгээ үзүүлж буй ААН, ТББ-д хяналт тавьж ажилладаг байна.


3.3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөв, санхүүжилт

3.3.1. Улсын хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд зарцуулсан зардал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны өгсөн мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2011 онд 3340.6 сая, 2012 онд 3450.6 сая, 2013 онд 5087.7 сая, 2014 онд 7184.6 сая, 2015 онд 1684.1 сая, 2016 онд 1266.5 сая, 2017 онд 651.2 сая, 2018 онд 3617.7 сая, 2019 онд 1696.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Доорх зурагт улсын хэмжээнд 2011-2019 онд ОНОТХҮ-нд зарцуулсан зардлыг харьцуулан харуулав.

График. Улсын хэмжээнд 2011-2019 онд ОНОТХҮ-нд зарцуулсан зардлын харьцуулалт (сая.төг)



Улсын дүнгээс үзэхэд 2014, 2013, 2018 онуудад ОНОТХҮ-ний зардал хамгийн өндөр байсан бол 2015-2017 онд энэ төрлийн задал хамгийн бага байсан нь харагдаж байна.

Харин улсын хэмжээнд 2019 онд ОНОТХҮ-ний зардалд 1,913,407,300 төгрөг төсөвлөснөөс 1,696,600,000 орчим төгрөг зарцуулсан бөгөөд төсвийн бодит зарцуулалт төсвөөс 216.8 сая орчим төгрөгөөр дутуу байв. Улсын хэмжээнд 2019 оны ОНОТХҮ-ний төсөв болон төсвийн зарцуулалтыг доорх зурагт харьцуулан харуулав.

График. ОНОТХҮ-ний 2019 оны төсөв болон төсвийн зарцуулалтын харьцуулалт (сая.төг)



Энэхүү мэдээллийг нарийвчлан дүгнэж үзвэл улсын хэмжээнд ОНОТХҮ-ний төсвийг 2019 онд Өвөрхангай аймаг 2.1 дахин бага зарцуулсан, Хөвсгөл аймаг 1.9 дахин бага зарцуулсан нь нь хамгийн бага хувиар зарцуулсан аймгууд байсан бол Улаанбаатар хотын хэмжээнд 1.2 дахин бага зарцуулсан боловч дутуу зарцуулсан дүнгээрээ хамгийн их буюу 147.4 сая төгрөг байжээ. Харин Сүхбаатар аймаг тус онд ОНОТХҮ-ний төсвөө 2.9 дахин илүү зарцуулсан, Сэлэнгэ аймаг 2.4 дахин их зарцуулсан нь хамгийн их дүнгээр давуулан зарцуулсан аймгууд байжээ.


Харин 2018 онд улсын хэмжээнд нэг үйлчлүүлэгчид оногдох ОНОТХҮ-ний дундаж зардал 170,485 төгрөг байсан бол 2019 онд дундаж зардал 110,932 төгрөг болж буурсан байна.

3.3.2. Нийслэлийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал

Нийслэлийн хэмжээнд ОНОТХҮ-ний зардалд 2018 болон 2019 онд ижилхэн 1,081,883 төгрөгийн зардлыг төсөвлөсөн бөгөөд эдгээрийг дүүргээр ангилж үзвэл

2018 онд Баянгол дүүрэгт 110,664, Баянзүрх дүүрэгт 256,424, Чингэлтэй дүүрэгт 140,688, Сүхбаатар дүүрэгт 101,802, Сонгинохайрхан дүүрэгт 209,824, Хан-Уул дүүрэгт 90,957, Багануур дүүрэгт 66,477, Багахангай дүүрэгт 45,490, Налайх дүүрэгт 59,557 төгрөгийг тус тус төсөвлөсөн бол, 2019 онд Баянгол дүүрэгт 103,498, Баянзүрх дүүрэгт 265,291, Чингэлтэй дүүрэгт 136,543, Сүхбаатар дүүрэгт 98,522, Сонгинохайрхан дүүрэгт 204,825, Хан-Уул дүүрэгт 116,903, Багануур дүүрэгт 60,590, Багахангай дүүрэгт 41,462, Налайх дүүрэгт 54,249 төгрөгийг тус тус төсөвлөсөн байна. Үүнийг харьцуулан доорх зурагт харуулав. Үүнд:

График. Нийслэлийн ОНОТХҮ-ний зардал дүүргээр (сая.төг)



Харин нийслэлийн хэмжээнд 2018 онд ОНОТХҮ-ний бүлгийн төслөөс бусад зардалд 626,413,350 төгрөгийг зарцуулсан бол 2019 онд энэ төрлийн зардалд 618,088,700 төгрөгийг зарцуулсан нь 1.33 хувь буюу 8,324,650 төгрөгөөр багассан байна. Ийнхүү багассан нь сэргээн засах үйлчилгээ болон өдрийн үйлчилгээний зардал тус тус багассанаас шалтгаалсан бөгөөд бусад бүх үйлчилгээний зардал дунджаар 33 орчим хувиар өссөн боловч нийт зардалд эзлэх хувь бага байсан тул нөлөөлөл нь бага байжээ (дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс үзнэ үү).

Хүснэгт 6. Нийслэлийн ОНОТХҮ-ний зарцуулалт болон үйлчлүүлсэн иргэдийн харьцуулалт (2018, 2019 он)

№	Үйлчилгээний төрөл	2018	2019
		Зарцуулалт	Зарцуулалт
1.	Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах	25,421,300	39,132,600
2.	Зөвлөгөө өгөх	7,293,000	24,342,000
3.	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	345,239,500	274,141,000
4.	Түр байрлуулан асрамжлах	14,318,100	21,939,100
5.	Өдрийн үйлчилгээнд хамруулах	44,425,250	47,919,500
6.	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	31,786,300	18,725,900
7.	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	157,929,900	191,888,600
	НИЙТ	626,413,350	618,088,700

Дээрх хүснэгтээс үзэхэд 2018 онд нийслэлийн хэмжээнд 5,118 иргэд, 2019 онд 5,652 иргэд үйлчлүүлсэн бөгөөд үйлчлүүлсэн иргэдийн тоо 10 орчим хувиар өссөн үзүүлэлттэй байх боловч нэг үйлчлүүлэгчид оногдох дундаж зардал 2018 онд 122,394 орчим төгрөг байсан нь 2019 онд 109,358 орчим төгрөг болж буурсан нь нийслэлийн хэмжээнд ОНОТХҮ-ний зардлын зарцуулалт багасахад илүү хүчтэй нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Нийслэлийн ОНОТХҮ-ний 2018 оны зардлыг дүүргүүдээр ангилж доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав. Үүнд:

Хүснэгт 7. Нийслэлийн ОНОТХҮ-ний 2018 оны зардлын төсөв, дүүргээр (мян.төг)

Дүүргийн нэр	Баянгол	Баянзүрх	Чингэлтэй	Сүхбаатар	Сонгино хайрхан	Хан-Уул	Багануур	Багахангай	Налайх	Дүн
Сургалт зохион байгуулах	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	54,094
Зөвлөгөө өгөх	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	54,094
Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	38,381	58,948	42,206	35,307	62,947	27,287	23,056	15,777	20,656	324,565
Түр байрлуулан асрамжлах	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	54,094
Ө д р и й н үйлчилгээнд хамруулах	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	54,094
Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	6,397	9,825	7,034	5,885	10,491	4,548	3,843	2,629	3,443	54,094
Гэр оронгүй иргэдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;	1,919	89,403	21,103	1,765	31,474	13,644	1,153	789	1,033	162,282
Бүлгийн төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах	38,381	58,948	42,206	35,307	62,947	27,287	23,056	15,777	20,656	324,565
НИЙТ ДҮН	110,666	256,424	140,685	101,804	209,823	90,958	66,480	45,488	59,560	1,081,882

Нийслэлийн 2019 оны ОНОТХҮ-ний зардлыг дүүргүүдээр ангилж доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав. Үүнд:

Хүснэгт 8. Нийслэлийн ОНОТХҮ-ний 2019 оны зардлын төсөв, дүүргээр (мян.төг)

Дүүргийн нэр	Баянгол	Баянзүрх	Чингэлтэй	Сүхбаатар	Сонгино хайрхан	Хан-Уул	Багануур	Багахангай	Налайх	Дүн
Сургалт зохион байгуулах	5,500	12,820	7,035	5,500	10,491	5,500	3,320	2,275	2,980	55,421
Зөвлөгөө өгөх	4,400	10,256	5,627	4,400	8,392	4,400	2,660	1,820	2,382	44,337
Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	41,076	56,949	42,206	40,307	59,947	32,000	23,055	15,776	20,655	331,971
Түр байрлуулан асрамжлах	3,320	7,692	4,220	3,055	6,295	2,728	1,995	1,365	1,786	32,456

Өдрийн үйлчилгээнд хамруулах	6,396	9,824	7,035	5,885	9,900	4,547	3,845	2,630	3,445	53,507
Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	3,320	9,800	4,220	3,055	9,800	2,728	1,995	1,365	1,786	38,069
Гэр оронгүй иргэдийн нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;	1,106	99,000	24,000	1,020	35,000	35,000	665	455	560	196,806
Бүлгийн төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах	38,380	58,950	42,200	35,300	65,000	30,000	23,055	15,776	20,655	329,316
Нийт	103,498	265,291	136,543	98,522	204,825	116,903	60,590	41,462	54,249	1,081,883

Нийслэлийн ОНОТХҮ-ний 2018 болон 2019 оны зардлын төсвийг харьцуулж үзвэл сэргээн засах үйлчилгээнд хамруулах үйлчилгээ, гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээний болон бүлгийн төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээний төсөв аль аль онд илүү өндөр байна.

Түүнчлэн хүн ам ихтэй Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд ОНОТХҮ-ний зардал ерөнхийдөө харьцангуй өндөр, бусад дүүргүүдийн дундаас Чингэлтэй болон Баянгол дүүргийн зардал харьцангуй өндөр байх бөгөөд нийт дүүргүүдийн хувьд амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, түр байрлуулан асрамжлах, өдрийн үйлчилгээнд хамруулах, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах үйлчилгээнүүдийн зардал жигд хэмжээнд харьцангуй бага байгаа нь ажиглагдаж байна.

Нийслэлийн дүүргүүдийн ОНОТХҮ-ний зардлын төрөл бүрээр ангилж үзвэл мөн л бүх төрөлд Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүд илүү өндөр, үүний дотор Баянзүрх дүүргийн гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээний хувьд Баянзүрх дүүрэг 2 дугаарт бичигдсэн өндөр (2018 онд 31.5 сая, 2019 онд 35.3 сая төгрөгийн) зардалтай Сонгинохайрхан дүүргийнхээс аль аль онд ойролцоогоор 2.8 дахин өндөр (2018 онд 89.4 сая, 2019 онд 99 сая төгрөгийн) төсөвтэй байгаа нь анхаарал татаж байв.

Харин Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдээс бусад дүүргүүдийн хувьд Чингэлтэй дүүрэг харьцангуй өндөр зардалтай байсан бол үүний дараа Баянгол, Хан-Уул дүүргүүд ОНОТХҮ-ний зардлаараа 2018 болон 2019 онуудад 4 болон 5-т жагсахаар өндөр зардалтай байсан байна. Хан-Уул дүүргийн хувьд 2018 онд Баянгол дүүргээс бага төсөвтэй, 2019 онд илүү төсөвтэй байсан боловч хоёр оны зардлын нийт дүнгээрээ Баянгол дүүрэг 4, Хан-Уул дүүрэг 5- жагссан байна.

Нийслэлийн ОНОТХҮ-ний 2018 болон 2019 оны зардлын төсвийг харьцуулсан үр дүнг доорх зурагт харуулав.

График. Нийслэлийн ОНОТХУ-ний 2018 болон 2019 оны зардлын төсвийн харьцуулалт, дүүргээр (сая.төг)



3.3.3. Баянзүрх дүүргийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардлын зарцуулалт

Баянзүрх дүүрэг нь ОНОТХУ-ний хувьд 2018 болон 2019 онуудад нийслэлийн бусад дүүргүүдээс хамгийн өндөр төсөвтэй дүүрэг байсан бөгөөд байна. Тус дүүргийн хувьд 2019 онд ОНОТХУ-нд нийт 180,557,400 төгрөг зарцуулснаас сургалт зохион байгуулахад 4.73 хувийг, зөвлөгөө өгөхөд 2.52 хувийг, сэргээн засах үйлчилгээнд хамруулахад 30.97 хувийг, түр байршуулан асрамжлахад 3.05

хувийг, өдрийн үйлчилгээнд хамруулахад 6.27 хувийг, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулахад 1.22 хувийг, гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулахад хамгийн их буюу 51.25 хувийг тус тус зарцуулсан байна. Үүнийг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харууллаа. Үүнд:


Хүснэгт. БЗД-ийн 2019 оны ОНОТХҮ-ний зардлын зарцуулалт

Д/д	Үйлчилгээний төрөл	ТББ	ХХК	Нийт байгууллага	Гүйцэтгэсэн үйлчилгээний тоо	Үйлчилгээний дүн
1	Сургалт зохион байгуулах	2	-	2	415	8,542,100
2	Зөвлөгөө өгөх	2	-	2	142	4,542,000
3	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	1	4	5	316	55,914,500
4	Түр байршуулан асрамжлах	1	-	1	4	5,506,800
5	Өдрийн үйлчилгээнд хамруулах	1	2	3	190	11,322,000
6	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	1	-	1	11	2,200,000
7	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	4	-	4	323	92,530,000
	Нийт	12	6	18	1,401	180,557,400

Дээрх хүснэгтээс үзэхэд БЗД нь 2019 онд нийт 1,401 хүнд 180,557,400 төгрөгийн ОНОТХҮ-г 18 байгууллагаар дамжуулан үзүүлсэн бөгөөд нэг үйлчлүүлэгчид дунджаар 128,877.52 төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн нь мөн онд нийслэлийн хэмжээнд нэг үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээний дундаж зардлаас 20 орчим мянган төгрөгөөр, улсын хэмжээнд нэг үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээний дундаж зардлаас 28 орчим мянган төгрөгөөр өндөр байна.

Улсын хэмжээнд 2019 онд ОНОТХҮ-ний зардалд 1,913,407,300 төгрөг төсөвлөснөөс 1,696,600,000 орчим төгрөг зарцуулсан бол БЗД-ийн ОНОТХҮ-ний зардал нь улсын хэмжээний зардлын 10 орчим хувийг, нийслэлийн ОНОТХҮ-ний зардлын 19 орчим хувийг эзэлж байна. Улсын хэмжээний ОНОТХҮ-ний зардлаас БЗД-ийн ОНОТХҮ-ний зардлын эзлэх хувь хэмжээг доор зурагт дэлгэрэнгүй харуулав. Үүнд:

График. Улсын хэмжээний ОНОТХҮ-ний зардлаас БЗД-ийн ОНОТХҮ-ний зардлын эзлэх хувь хэмжээ



Дээрх зургаас үзэхэд БЗД нь 2019 онд гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулахад ОНОТХҮ-ний зардлаас хамгийн их буюу 51.25 хувийг зарцуулсан нь улсын хэмжээнд зарцуулсан ОНОТХҮ-ний зардлын 5 орчим хувийг, сэргээн засах үйлчилгээнд хамруулахад ОНОТХҮ-ний зардлын 30.97 хувийг зарцуулсан нь улсын хэмжээнд зарцуулсан ОНОТХҮ-ний зардлын 3 орчим хувийг эзэлж байжээ.

ДӨРӨВ. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙХ ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явц нь агуулгын хувьд чухал ач холбогдолтой нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ. Үнэлгээний өмнөх хэсэгт авч үзсэнчлэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжид хамрагдах өрх иргэнд үйлчилгээг үзүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодруулан, хууль тогтоомжийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэв.

4.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжид хамрагдах өрх иргэнд үзүүлж буй үйлчилгээний төрөл, хэлбэр

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

Үнэлгээний зүйл 1.

18 дугаар зүйл. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
18.1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:
18.1.1. амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;
18.1.2. зөвлөгөө өгөх;
18.1.3. сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
18.1.4. түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;
/Энэ заалтад 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/
18.1.5. өдрийн үйлчилгээнд хамруулах;
18.1.6. гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
18.1.7. иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
18.1.8. гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
18.1.9. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.
18.1.10. гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах.
/Энэ заалтыг 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/
18.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд дараах өрх, иргэн хамрагдана:
18.2.1. ахмад настан;
18.2.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
18.2.3. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд
/Энэ заалтыг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/
18.2.4. хүчирхийлэлд өртсөн иргэн;
18.2.5. хорих ангиас суллагдсан иргэн;
18.2.6. согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;
18.2.7. эдгэшгүй хүнд өвчтэй хүн;
18.2.8. гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;
18.2.9. шилжин суурьшсан энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн-иргэн, иргэн;
18.2.10. өрх толгойлсон эх /эцэг/.
18.2.11. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх.
/Энэ заалтыг 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/
18.2.12. гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн хүүхэд.
/Энэ заалтыг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/

Шалгуур үзүүлэлт. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

Уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтад заасан “Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих” зорилгоор 1/ Амьдрах ухааны болон бие даан амьдрах ур чадвар эзэмшүүлэх, 2/ Хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах, 3/ Амьдралын итгэл үнэмшил бий болгох сургалт зохион байгуулах гэсэн үйлчилгээний чиглэлтэй байх бол үйлчилгээний хэлбэрийг дараах байдлаар зохион байгуулдаг байна. Үүнд:

1. Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж бий болгох;
2. Зорилтот бүлгийн гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулах;
3. Өдөр тутмын амьдралын дарамт, стрессийг даван туулах чадварыг бий болгох;
4. Эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх;

5. Тодорхой бэрхшээл, эрсдэлээс зайлсхийх, даван туулах, урьдчилан сэргийлэх чадварыг бий болгох;

6. Мэргэжлийн чиг баримжаа олгох зэрэг сургалт хамаарах юм.

Эдгээр үйлчилгээнд дараах өрх, иргэн хамруулдаг.

1. Ахмад настан;

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

3. Хүчирхийлэлд өртсөн иргэн;

4. Хорих ангиас суллагдсан иргэн;

5. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;

6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;

7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

8. Өрх толгойлсон эх /эцэг/;

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад заасан “Зөвлөгөө өгөх” үйлчилгээг хууль зүйн зөвлөгөө, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр үзүүлдэг бөгөөд 1/ амьдралын асуудлаа өөрсдөө шийдвэрлэхэд туслах, 2/ тулгарч буй сэтгэл зүйн асуудал, бэрхшээлтэй нөхцөл байдлыг оношлон тогтоох, шийдвэрлэхэд нь мэргэжлийн тусламж, дэмжлэг үзүүлэх хэлбэрээр дараах өрх, иргэдийг хамруулдаг байна. Үүнд:

1. Ахмад настан;

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

3. Хүчирхийлэлд өртсөн иргэн;

4. Хорих ангиас суллагдсан иргэн;

5. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;

6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;

7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

8. Өрх толгойлсон эх /эцэг/;

9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн

Уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтад заасан “Сэргээн засах” үйлчилгээг 1/эрүүл мэнд, 2/Боловсрол, 3/Хөдөлмөр, 4/Нийгэм-сэтгэл зүйн чиглэлээр а/ Хэл, хөдөлгөөн, ахуйн, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, б/ эзэмшсэн мэргэжлийг нь сэргээх, ур чадварыг нь сайжруулах, в/ алдагдсан чадварыг сэргээхэд чиглэсэн орчныг бүрдүүлэх, сэтгэл зүйн нөлөөллийг үзүүлэх, г/ нийгмийн зан үйл, нөлөөллийн аргуудыг ашиглах замаар хүмүүсийн харилцааны боломжит нөхцөлийг бүрдүүлэх, д/ Боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх, ахуйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай байгууллагын үйл ажиллагаанд хамруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал хийх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх хэлбэрээр дээрх 9 чиглэлийн өрх, иргэдийг мөн адил хамруулдаг байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтад заасан “Түр байрлуулан асрамжлах” үйлчилгээг 1/ хүчирхийлэлд өртөх магадлалтай иргэдийг урьдчилан сэргийлэх, 2/хүчирхийлэлд өртсөн иргэдэд стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр а/ бичиг баримтжуулах, б/эрүүл мэндийн болон хууль зүйн үйлчилгээ үзүүлэх, в/ хөгжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, г/ холбон зуучлах, д/ хүүхдэд бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх, е/халуун хоол цайгаар үйлчлэх хэлбэрээр дараах өрх, иргэдийг хамруулдаг байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

2. Хүчирхийлэлд өртсөн иргэн;

3. Хорих ангиас суллагдсан иргэн;

4. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;

5. Шилжин суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн -иргэн;

6. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд;

Уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтад заасан “Өдрийн үйлчилгээ” нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, амьдрах ухаанд сургах юм. Өөрөөр хэлбэл, 1/ахмад настны өдрийн үйлчилгээ, 2/ хүнд нөхцөлд байгаа хүүхдийн өдрийн үйлчилгээ, 3/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдрийн үйлчилгээ үзүүлэх, 4/ хөгжлийн бэрхшээлтэй иргэний өдрийн үйлчилгээг соёл, урлаг биеийн тамир спортын арга хэмжээнд оролцуулах, сэргээн засах, амьдрах ухаанд сургах, зөвлөгөө өгөх хэлбэрээр ахмад настан, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хүүхэд хамруулдаг байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалтад заасан “гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах” үйлчилгээг а/гэр ахуйн үйлчилгээ үзүүлэх, б/өдөр тутмын асаргааны үйлчилгээ үзүүлэх, в/гадуур ажилд туслах үйлчилгээ үзүүлэх, г/эрүүл мэнд, эмчилгээний дэглэм сахиулах, д/хоол хүнс бэлтгэх, хоолны дэглэм сахиулах, хооллож ундлах хэлбэрээр байнгын асаргаатай ахмад настан, байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд гурвыг хамруулдаг.

Уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7 дахь заалтад заасан “иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх”-д өрх, иргэний амьдралын нөхцөл байдлыг өөрсдийнх нь оролцоотойгоор үнэлэх, өрх, иргэний нөөц боломж чадавхи хэрэгцээнд тохирох үйлчилгээг туршин хэрэгжүүлэх чиглэлээр өөрсдөө бие даан хөгжих боломжийг нь судалж, өрхийн нөхцөл байдлыг судлан үнэлэх, нөөц боломж, чадавхийг тодорхойлж, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн болон хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр дараах өрх, иргэдийг хамруулдаг байна. Үүнд:

1. Ахмад настан;

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

3. Хүчирхийлэлд өртсөн иргэн;

4. Хорих ангиас суллагдсан иргэн;

5. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;

6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн

7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн -иргэн;

8. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн;

9. Өрх толгойлсон эх /эцэг/;

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.9 дэх заалтад заасан “нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах”-даа а/төсөл бичих, түүнийг хэрэгжүүлэх амьдрах ухааны сургалтад хамруулах, зөвлөгөө өгөх, б/хамт олны бүлэг бүрдүүлж орлого нэмэгдүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр 1/төсөл бичих чадвартай болгох, 2/багаар ажиллах чадвартай болгох. 3/ тухайн төслөө хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвартай болгох, 4/тухайн төслийг цааш нь өргөжүүлэх санхүүгийн эх үүсвэртэй болох хэлбэрээр дараах өрх, иргэдийг хамруулдаг байна. Үүнд:

1. Ахмад настан;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
3. Хүчирхийлэлд өртсөн иргэн;
4. Хорих ангиас суллагдсан иргэн;
5. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн;
6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;
7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;
8. Өрх толгойлсон эх /эцэг/;
9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн

2016 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” батлагдан дагаж мөрдөгдөх болсонтой холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт өмнө нь “...түр байрлуулах асрамжлах...” гэж байсныг 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтын “асрамжлах” гэсний дараа “, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах” гэж нэмэн “...түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах...” болгосон юм.

Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Нийгмийн халамжийн тухай хуулийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуультай уялдуулах, хууль хоорондын уялдааг хангах алхам болсон хэдий ч давхардлыг бий болгосон гэж үзэж болохоор байгаа юм. Учир нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.4-т заасан “...түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах...” гэдэгт тус хуулийн 18.1.10-т заасан “... гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах...” ойлголт мөн адил хамаарч байгаа юм. Үүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд давхардуулан тусгажээ.

Мөн 18 дугаар зүйлийн 18.1.4-т заасан “...түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах...” зохицуулалтад 18 дугаар зүйлийн 18.1.8-гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээ давхардуулан зохицуулагдсан байна. Түр байрлуулан асрамжлах болон түр хоноглох байранд байлгах үйлчилгээ нь утгын хувьд адил зохицуулалт төдийгүй гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах үйлчилгээг үзүүлдэг байна.

Ахмад настан нь нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдахаас гадна төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагддаг байна. Гэсэн хэдий ч Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд “Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ нь дараах төрөлтэй байна” хэмээн лавлагаа мэдээллийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ, явуулын үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, сайн дурын үйлчилгээ, өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ, асрамжийн үйлчилгээ, хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ гэх 9-н төрлийн үйлчилгээг тусгаж өгсөн гэтэл эдгээр үйлчилгээнээс хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, явуулын үйлчилгээнээс бусад үйлчилгээг нийгмийн халамжийн тухай хуультай давхардуулан хуульчилсан байна.

Ийнхүү дүгнэн үзвэл: Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалттай агуулгын хувьд давхардсан 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтад гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээ болон 18 дугаар зүйлийн 18.1.10 дахь заалтад заасан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах” гэсэн давхардсан зохицуулалтыг хасах, мөн Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийг хуулийн

заалттай нийцүүлэх нь зүйтэй юм.

4.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хяналт, оролцоо

Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8, 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсэг

Үнэлгээний зүйл 2

Нийгмийн халамжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)

24.8. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн олголт, үйлчилгээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 24.7-д заасан мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гаргах чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байна.

24.9. Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 24.8-д заасан чиг үүрэг бүхий ажилтантай байна.

Шалгуур үзүүлэлт. Практикт нийцсэн байдал

Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар: 2005 оны Нийгмийн халамжийн тухай хуульд эрх олгосон зохицуулалтыг уг хуулийн 24 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн олголт, үйлчилгээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 24.7-д заасан мэргэжлийн хяналтын байгууллагад хүсэлт гаргах чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байна”, 9 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 24.8-д заасан чиг үүрэг бүхий ажилтантай байна.” хэмээн заавал нэгж ажилтантай байхаар тусгаж өгсөн бөгөөд уг заалтаас үндэслэн хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Тодруулбал, Олон нийтийн оролцоот халамжийн үйлчилгээний хяналтыг нийгмийн халамжийн мэргэжилтнүүд ажиллаж буй шат шатандаа олон нийтийн, мэргэжлийн байгууллагын, гүйцэтгэлийн хяналтыг тавьдаг байна. Хорооны нийгмийн халамжийн мэргэжилтнүүд өдөр тутам үйл явцын хяналтыг үйлчилгээнд хамрагдсан иргэн, үйлчилгээг хэрэгжүүлэх байгууллага бүрээр тогтмол хийдэг бол дүүргийн нийгмийн халамжийн мэргэжилтэн стандартын биелэлт, хөрөнгийн зарцуулалт, гэрээний биелэлтийг хянадаг. Мөн нийгмийн халамжийн байгууллагын дотоод хяналтын албаныхан аймаг дүүргийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийг түүвэрлэн давхар хянадаг байна.¹³⁸

Уг хяналтын тогтолцоог хэрхэн хэрэгждэг, үр дүнтэй байдал зэргийг тодруулах үүднээс холбогдох мэргэжилтнүүдээс ярилцлагын аргаар судалгаа авахад дараах хариултыг өгсөн байна.

Дүүргийн хэмжээнд хяналт үнэлгээ, шинжилгээ хариуцдаг 2 албан хаагч ажилладаг эдгээр нь бүх байгууллага бүх иргэнийг хамруулан хяналт хийх боломжгүй байдаг учраас түүврийн аргаар хяналтыг хэрэгжүүлдэг. Хяналтын зардал байхгүй, хяналт хийх талаар хуульд тусгаж өгсөн ч гэсэн хэт ерөнхий учир ойлгомжгүй байдаг талаар дурдсан байна.¹³⁹

Монгол Улсын нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ хэт өргөн буюу жилд 730.0 орчим мянган хүнийг хамарч, 4 хүн тутмын нэгд төрөөс халамж үзүүлж байгаа нь халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт чиглээгүй хэмээх үндэслэлээр “Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулан хуулийн төсөлд санал авах ажиллагаа явагдаж байна.”¹⁴⁰ Уг

¹³⁸ Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн нөлөөллийн шинжилгээ “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”, 2017 он, 29 дэх тал.

¹³⁹ Баянзүрх дүүргийн халамжийн албаны дарга Ш.Ганцэцэг /ярилцлагаас/

¹⁴⁰ “Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл <http://www.mlsp.gov.mn/nnews/431> сүүлд үзсэн 2020.05.26

төсөлд дээр дурдсан эрх зүйн асуудлыг хэрхэн зохицуулсан талаар авч үзвэл:

Төслийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрлийг:

- Хувь хүнийг хөгжүүлэх, нийгмийн амьдралд орох оролцоог дэмжих үйлчилгээ;
- Өдрийн үйлчилгээ;
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ;
- Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг түр байрлуулах үйлчилгээ;
- Орлогын эх үүсвэртэй болгоход чиглэсэн төслийг дэмжих үйлчилгээ;
- Орон нутгийн онцлогт тохирсон бусад үйлчилгээ гэх зургаан төрлийн үйлчилгээг оруулж өгсөн байна.

Төслийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг дараахь үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.” хэмээн 33.1.8 дахь заалтад “нийгмийн халамжийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний зардал” гэж хяналтын тухай тусгасан байна. Уг заалтыг төсөлд тусгаж өгснөөр одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хяналт хэрэгжихгүй байх нэг үндэслэл болсон зардлын асуудлыг шийдэж өгөх зохицуулалтыг тусгасан байна.

Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар: Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гүйцэтгүүлдэг. Ийнхүү гэрээ байгуулан тухайн халамжийн үйлчилгээг авч хэрэгжүүлэхэд хэд хэдэн асуудал тулгамдаж буйг онцгойлон дурдвал:

- Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа тогтвортой бус, зарим байгууллагын хувьд тухайн халамжийн үйл ажиллагаа явуулахын тулд байр түрээслэх, хэсэг хугацааны дараа үйл ажиллагаагаа зогсоох гэх мэт асуудал тулгардаг.
- Түүнчлэн, харьцангуй тогтвортой ажиллаж, сургалт, зөвлөгөө өгөх мэргэжлийн баг хамт олон, орчин нөхцөл бүрдүүлсэн байгууллагын тухайд зарласан тендерт тавигдаж буй мөнгөн дүн, нэг удаагийн сургалтын зардал, түүнд олгогдож буй санхүүжилт бага байдгаас олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх сонирхол бага байдаг.
- Зөвлөгөө үзүүлэх үйлчилгээнд мэргэжлийн хуульч, сэтгэл зүйч байх шаардлагатай байдаг, сургалт явуулах тохиолдолд мэргэжлийн арга зүйч багш байх, түр байрлуулах үйлчилгээнд байр сууцтай байх, тоног төхөөрөмжтэй байх зэрэг шаардлагыг хангах нь байнгын орлогогүй хуулийн этгээдэд хүндрэл үүсгэж байдаг.

Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын / Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар/ дэргэдэх магадлан итгэмжлэх Орон тооны бус зөвлөл магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хариуцдаг. /Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхээр 2019 онд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж байгууллагын нэрсийн жагсаалтыг хавсралт №.... үзнэ үү./

Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй байгууллагуудын хувьд хэд хэдэн асуудал гардаг байна. Тухайлбал, бичиг баримтын бүрдүүлбэр дутуу, албан бичиг хөтлөлтийн стандарт болон бусад шаардлага хангахгүй материалууд ирүүлдэг байна. Гэтэл хөдөө орон нутаг, зарим дүүргүүдийн хувьд тухайн олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйл ажиллагаа явуулах магадлан итгэмжлэл авсан байгууллага тухайн орон нутагт нь байдаггүйгээс энэхүү үйлчилгээнд

хамрагдаж чадахгүй байх тохиолдол үүсдэг учир магадлан итгэмжлэх ажиллагаанд өндөр шалгуур тавих боломж байдаггүй талаар ярилцлагын судалгааны явцад хэлж байсан болно. Мөн магадлан итгэмжлэл авсан хэдий ч үйл ажиллагаа огт явуулдаггүй байгууллагууд ч байдаг байна.

Хөдөө орон нутаг, зарим дүүргүүдийн хувьд Нийгмийн халамжийн тухай хуульд заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн 10 төрлийн үйлчилгээнээс зарим төрлийн үйлчилгээ огт хийгдэхгүй байх тохиолдлууд цөөнгүй гардаг байна. Энэ тухайн орон нутаг, сум, дүүрэгт олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх сонирхолтой аж ахуйн нэгж байгууллага байдаггүй байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд тавигдах санхүүжилт нь тухайн орон нутгийн сангаас төсөвлөгдөн тавигддаг. Тиймээс тухайн санхүүжилтэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ямар нэгэн хяналт тавьдаггүй бөгөөд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад тавьж буй хяналтын хувьд сум, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн хяналт шинжилгээ үнэлгээний албаны мэргэжилтэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллагуудын нөхцөл байдалтай танилцах, санамсаргүй түүврийн аргаар тухайн үйлчилгээнд хамрагдсан иргэдтэй холбогдон мэдээлэл авч хяналт тавин ажилладаг байна.

Ийнхүү үнэлгээний зүйл 2-ийг дүгнэж үзвэл: ТББ-ын нийгмийн оролцоо, санхүүгийн чадавх сул /үйл ажиллагаа явуулах байр, тоног төхөөрөмж гэх мэт зүйл байдаггүй/, хүний нөөц, ажиллах хүч байдаггүй зэрэгтэй холбоотой орон нутаг, дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн хяналт шинжилгээ үнэлгээний алба хяналт тавин ажилладаг хэдий ч тус алба нь орон тооны хувьд дутмаг, мөн хяналт тавихад шаардагдах төсөв санхүүжилт гэж байдаггүй байна. Тиймээс ажлын ачаалал, хөрөнгө санхүүтэй холбоотойгоор хяналтыг бүрэн хэрэгжүүлэхэд боломж хязгаарлагддаг.

Түүнчлэн, хуульд заасан 10 төрлийн үйлчилгээнээс иргэд сэргээн засах, бүлгийн төслийн үйлчилгээ хүртэх сонирхолтой байдаг ч бусад үйлчилгээнд хамрагдах сонирхолтой иргэдийн тоо бага байдаг байна. Тухайн аймаг, сум, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн ОНОТХУ хариуцсан мэргэжилтэн иргэдийг хамруулах үйл ажиллагаа зохион байгуулдаг бөгөөд энэ нь хуульд заасан шат дарааллын дагуу бус харин ч эсрэг урсгалаар хийгддэг байна. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн үйлчилгээнүүдэд хамрагдах иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 2008 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд ОНОТХУ үзүүлэх журмыг баталж, 2011 оноос ОНОТХУ-г хэрэгжүүлэх иргэн, ААН, ТББ-аар гүйцэтгүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.¹⁴¹

ДҮГНЭЛТ

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо сайн байх нь ирээдүйд илүү үр дүнтэй нийгмийн халамжийн үйлчилгээ хэрэгжүүлэх боломжийг Засгийн газарт олгоно. Дээрх үйлчилгээний төрлөөс хийгдсэн ажлын үр дүнгийн үнэлгээ өнөөдрийг хүртэл хийгдээгүй тул Засгийн газар эцсийн үр дүн ямар байгааг, хэрхэн сайжруулж болох тал дээр ойлголт багатай байна.

ОНОТХУ нь нийгмийн зорилтот бүлгийг бүхэлд нь хамрах боломжтой төдийгүй иргэдийн санаачилга оролцоог дэмжих өргөн талбар хэдий ч салбарын мэргэжилтнүүдийн ажлын ачаалал их, орон тоо дутмаг байдгаас тухайн төсөл

¹⁴¹ Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн нөлөөллийн шинжилгээ "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ", 2017 он, 6 дахь тал.

хөтөлбөр, тогтоол, шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг талаар мэргэжилтнүүдийн ажилтай танилцах явцад, мөн ярилцлага хийх явцад ажиглагдсан. Төрөөс тавигдах санхүүжилт нь тухайн орон нутгийн сангаас төсөвлөгдөж буй хэдий ч зарцуулалтад төдийлөн хяналт тавьдаггүй байгаа нь зарим нэг тоо баримтын зөрүү үүсч байгаагаас харж болох юм.

Энэхүү үйлчилгээнд төрийн дэмжлэг туслалцаа, үйлчилгээ нь бодлого, шийдвэрээр дамжин хууль тогтоомжийн уялдаа холбоог ханган нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээ гэдэг утгаар хэрэгжүүлэх нь чухал бөгөөд санхүүжилт гол үүрэг гүйцэтгэхгүй болох нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, 2011 оны санхүүжилт 3,340,6 сая байхад 42,845 мянган иргэн хамрагдаж байсан бол 2018 онд 3,617,7 сая төгрөгийн төсөвт 21,220 иргэнийг хамруулсан байгаа нь хамрагдсан иргэдийн тоо 50 хувиас илүү буурсан үзүүлэлттэй байгаа юм.

Тиймээс тухайн санхүүжилтэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас хяналт тавьдаггүй бөгөөд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад тавьж буй хяналтын хувьд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох мэргэжилтэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллагуудын нөхцөл байдалтай танилцах, санамсаргүй түүврийн аргаар тухайн үйлчилгээнд хамрагдсан иргэдтэй холбогдон мэдээлэл авч хяналт тавин ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хамаарах 6 гол хуулиас гадна бусад холбогдох хууль тогтоомж хоорондын уялдаа холбоог хангах шаардлагатай төдийгүй “түр байрлуулан асрамжлах” болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэх харилцаа хоорондоо давхардсан, зөрчилдсөн, зохицуулагдаагүй орхигдсон асуудал нэлээд байна.

Хөдөө орон нутаг, зарим дүүргүүдийн хувьд олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйл ажиллагаа явуулах магадлан итгэмжлэл авсан байгууллага тухайн орон нутагт нь байдаггүйгээс энэхүү үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх тохиолдол үүсдэг магадлан итгэмжлэх ажиллагаанд өндөр шалгуур тавих боломжгүй байгаа нь үйлчилгээ эрхлэх хүсэлтэй байгууллагын оролцоог дэмжсэн бодлого хэрэгтэй байна. Үйлчилгээ эрхлэх хүсэлтэй байгууллагууд магадлан итгэмжлүүлэх хүсэлтээ Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газарт гаргадаг хэдий ч бичиг баримтын бүрдүүлбэр дутуу, албан бичиг хөтлөлтийн стандарт болон бусад шаардлага хангахгүй материалууд ирүүлснээс үүдэн буцах, тэнцэхгүй байх тохиолдол элбэг байна.

Мөн магадлан итгэмжлэл авсан хэдий ч үйл ажиллагаа огт явуулдаггүй байгууллагууд байдаг нь ОНОТХУ-г хэрэгжүүлэх арга туршлага, зардлын зарцуулалт тодорхой биш, нөгөө талаас энэ үйлчилгээний үүрэг, ач холбогдлын ойлголт хангалтгүй байдагтай холбоотой байна.

ОНОТХУ чиглэлээр төсөв төдийлэн хангалттай байдаггүй ч хяналт шалгалт тавигдах, аливаа байдлаар үйл явцад саад учруулах, хүнд нөхцөлд байгаа иргэдэд туслалцаа үзүүлэхэд дотоод, гадаад хүчин зүйлээс шалтгаалах хүндрэлтэй нөхцөл үүсдэг, мэргэжлийн боловсон хүчний дарамт илүүтэй учирдаг нь энэ төрлийн үйл ажиллагаа явуулах иргэдийн сонирхол төрөхгүй нь лавтай.

САНАЛ

- Хэрэгжүүлж байгаа үйлчилгээний талаарх захиргааны мэдээлэлд тогтмол давтамжтай дүн шинжилгээ хийж шийдвэр гаргахад ашиглах.
- Асуудлуудыг шийдвэрлэхийн тулд олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага, иргэдийг дэмжих, чадавхжуулахад анхаарах;
- Албан ёсны сургалт, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн, хууль зүйн зөвлөгөө зэрэг мэргэжлийн байгууллага гүйцэтгэх үйлчилгээг үзүүлэхэд төрөөс дэмжлэг болох эрх зүйн зохицуулалтыг бий болгож өгөх, /мэргэжлийн чиглэлийн үйлчилгээ үзүүлэх төлбөрийн зарим хэсгийг төр хариуцах буюу эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, хууль зүйн салбар дахь төр, хувийн хэвшлийг ОНОТХҮ эрхлэх боломжоор хангах, татан оролцуулахад төрөөс анхаарал хандуулах шаардлагатай байна/
- Төрөлжсөн асрамж буюу удаан хугацаагаар байрлуулан асрамжлах үйлчилгээнээс ОНОТХҮ буюу түр хугацаагаар үйлчилгээ үзүүлэх ойлголтыг нийтэд түгээх;
- Хяналт, шинжилгээний ажилтны хийгдэх ажиллагааг нарийн тодорхой тусгах;
- Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ болон бусад үйлчилгээг сайжруулахад хууль тогтоомж хоорондын уялдаа холбоог хангах, (Нийгмийн халамжийн тухай хуулийн ОНОТХҮ-тэй холбоотой заалтыг бусад хуультай уялдуулах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалт нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зохицуулалт гэх мэт)
- Хүний эрхийг хангах хамгаалах бүхий л тогтолцоог өөр хооронд нь уялдуулан холбох нийгмийн сайн сайхны төлөө чиглүүлэх,
- Нийгмийн халамжийн тогтолцоо нь нийгмийн хамгааллын тогтолцоотой харилцан хамааралтай байх,
- Цахим орчинг нийгмийн халамжийн тогтолцоотой уялдуулах, ингэхдээ хувь хүний нууцыг хамгаалах,

НОМ ЗҮЙ**Эрх зүйн актууд**

- Ахмад настны тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №13
- Алдар цолтой ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №13
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №29
- Нийгмийн халамжийн тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2012, №8
- Нийгмийн халамжийн тухай хууль /2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/, 2005.
- Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, 2010, №31
- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2003, №44
- Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2018, №46
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2011, №40
- Хүүхдийн эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №9
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №27
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр/, 2017.11.29, Дугаар 321
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай /Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах/, 2019.04.23, Дугаар 159,
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, “Ахмад насны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөр” батлах тухай, 2020.03.04, Дугаар 84
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай, 2016.02.04, Дугаар 16
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Үндэсний хөтөлбөр батлах тухай /Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр/, 2019.10.30, Дугаар 389
- Монгол Улсын Засгийн Газрын тогтоол, Аргачлал шинэчлэн батлах тухай /Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал/, 2019.12.18, Дугаар 445
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Журам, загвар шинэчлэн батлах тухай /Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх/, 2019.02.14, Дугаар А/65
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Сургалт зохион байгуулах үйлчилгээний чанарт тавигдах шалгуур батлах тухай, 2019.12.26, Дугаар А/374
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,

Эрүү мэндийн сайдын хамтарсан тушаал, Журам батлах тухай /Хохирогчид үйлчилгээ үзүүлэх Төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх/, 2017.04.06, Дугаар А/84/А/59/А/130

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

- Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн нөлөөллийн шинжилгээ, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, 2017.
- Нийгмийн халамжийн салбар дахь төрийн үйлчилгээ-Хүний эрх ба хүнд суртал, 2012.
- Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн дизайн, үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Дэлхийн банк, 2015.
- Удирдахуйн онол, практикийн асуудлууд /эрдэм шинжилгээний бичиг/, Удирдлагын академи, 2011.

Цахим эх сурвалж

- mlsp.gov.mn, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- ub.hudulmur-halamj.gov.mn, Нийслэлийн нийгмийн халамжийн газар
- <https://wol.iza.org/uploads/articles/104/pdfs/how-to-improve-participation-in-social-assistance-programs.pdf>
- <https://socialwelfare.library.vcu.edu/public-welfare/origins-of-the-state-federal-public-welfare-programs/>
- <https://childwelfaresparc.files.wordpress.com/2013/02/child-welfare-financing-in-the-united-states-final.pdf>
- <https://www.aihw.gov.au/reports-data/health-welfare-overview/australias-welfare/overview>

№	Хуулийн нэр	Батлагдсан он, сар, өдөр	Холбогдох зүйл, заалт
1.			6.2.Ахмад настан хүнс тэжээл, орон байраар хангагдах, ахуйн болон эрүүл мэнд, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах эрхтэй бөгөөд ахмад настанд олгох тэтгэвэр, тэтгэмжийг холбогдох хуулиар зохицуулна. 6.8.Ахмад настан өөрийгөө хөгжүүлэх эрхтэй бөгөөд өөрийн чадавхийг хөгжүүлэх бололцоогоор хангагдах, сургалтад хамрагдах хэлбэрээр энэ эрхээ эдэлнэ. 7.1.Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ дараахь төрөлтэй байна: 7.1.2.зөвлөгөө өгөх үйлчилгээ; 7.1.4.өдрийн үйлчилгээ; 7.1.5.сайн дурын үйлчилгээ; 7.1.6.өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ; 7.1.7.асрамжийн үйлчилгээ; 7.1.8.хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ; 7.1.9.гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ. 7.2.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг дараахь хэлбэрээр зохион байгуулна: 7.2.1.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, ахмадын байгууллага нь ахмад настан, түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагчид дэмжлэг, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх, ахмад настны эрхийг хамгаалах асуудлаарх мэдээллийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр хүргэх, сургалт зохион байгуулах; 7.2.2.ахмад настанд нийгэм, эдийн засаг, сэтгэл зүй, хууль зүйн зөвлөгөө өгөх болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх; 7.2.3.ахмад настанд ус, түлш, хүнс бэлтгэх, угаалга цэвэрлэгээ хийх зэрэгт туслах, зайлшгүй шаардлагатай асаргаа, сувилгааг явуулын үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулах; 7.2.4.ахмад настныг хооллох, сургах, хөгжүүлэх үйлчилгээг өдрийн, эсхүл түр байрлуулах хэлбэрээр зохион байгуулах; 7.2.5.ахмад настанд туслах хүсэл, сонирхолтой сайн дурын байгууллага, ажилтны үйл ажиллагааг зохион байгуулах; 7.2.6.хүнд өвчтэй, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настныг сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвөөс өдрийн эмчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын тусламж, үйлчилгээнд хамруулах бөгөөд шаардлагатай тохиолдолд гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлэх; 7.2.7.бие даан амьдрах чадваргүй ахмад настныг Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан асрамжийн үйлчилгээнд хамруулах; 7.2.8.Нийгмийн халамжийн тухай хуулийн 22.1.1-д заасан өрхийн ахмад настанд хүнсний бүтээгдэхүүн авах эрхийн бичиг олгох; 7.2.9.шаардлагатай тохиолдолд ахмад настныг холбогдох хуульд заасны дагуу хүчирхийллээс хамгаалах үйлчилгээнд хамруулах; 7.2.10.аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан нь ахмад настны нөхцөл байдлыг судлан, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг тодорхойлж, тэдгээрээс сонголт хийхэд туслах, зөвлөгөө өгөх. 7.3.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.8-д заасан шалгуур, журмыг хангасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаас сонгон шалгаруулж, гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх бөгөөд үйлчилгээ нь өрх, иргэний хүсэлтийн дагуу төлбөртэй байж болно. 7.4.Энэ хуулийн 7.3-т заасан иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээллийн санг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүрдүүлнэ.

2.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	2016.12.22.	13 дугаар зүйл. Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 13.1.Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: 13.1.1.түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах; 13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг давтан сургах хөтөлбөр болон сургалт зохион байгуулах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих; 22 дугаар зүйл. Төрийн бус байгууллагын чиг үүрэг 22.1.3.хохирогчийг түр хамгаалах байраар хангах болон энэ хуульд заасан бусад үйлчилгээ үзүүлэх. 35 дугаар зүйл. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ 35.1.Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлнэ.
3.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль	2013-07-05	7 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ 7.1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна: 7.1.6.аюулгүй газарт түр байрлуулах; 13 дугаар зүйл.Аюулгүй газарт түр байрлуулах 13.1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.
4.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /Шинэчилсэн найруулга/	2019-06-06	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг тогтооход оршино. 5 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зарчим 5.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дараах зарчмыг баримтална: 5.1.6. олон нийтийн оролцоонд түшиглэсэн, хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн байх; 5.1.7.төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох.
5.	Дээд боловсролын тухай хууль		12 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын эрх, үүрэг 12.1.Дээд боловсролын сургалтын байгууллага дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 12.1.13.иргэдийн боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх болон нийгмийн халамж, хүмүүнлэгийн чиглэлийн үйлчилгээ үзүүлэх.

6.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль	2017.05.18	4.1.8.“амьдрах ухааны чадвар” гэж гэр бүл төлөвлөлт, санхүүгийн мэдлэг болон эрүүл, аюулгүй ажиллах, амьдрах зан үйл, дадал төлөвшил, нийгэм сэтгэл зүйн чадварыг; 7 дугаар зүйл.Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэл 7.1.Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараахь чиглэлээр зохион байгуулна: 7.1.1.хувь хүний хөгжил; 7.1.2.боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан; 7.1.3.эрүүл мэнд; 7.1.4.хөдөлмөр эрхлэлт; 7.1.5.аюулгүй амьдрах, хөгжих орчин. 8 дугаар зүйл.Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих 8.1.Залуучуудын хувь хүний хөгжлийг дараахь чиглэлээр дэмжинэ: 8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих; 8.1.3.түүх, соёлоо мэддэг, эх оронч үзэлтэй, бие дааж амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд чиглэсэн амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хөтөлбөрийн дагуу цэргийн мэргэжил олгох сургалтад 18-27 насны залуучуудыг хамруулах; 9 дүгээр зүйл.Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих 9.1.Залуучуудын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшүүлэхийг дараахь чиглэлээр дэмжинэ: 10 дугаар зүйл.Залуучуудын эрүүл мэндийг хамгаалах 10.1.Хорт зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй иргэн болж төлөвшүүлэх зорилгоор залуучуудын эрүүл мэндийг дараахь чиглэлээр дэмжинэ: 11 дүгээр зүйл.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 11.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дараахь чиглэлээр дэмжинэ: 1.1.6.мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулах; 12 дугаар зүйл.Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх 12.1.Залуучуудын аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг дараахь чиглэлээр дэмжинэ: 12.1.2.залуучуудыг гэмт хэрэгт татагдан орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах; 12.1.3.хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулах; 12.1.4.гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлсэн залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед ажлын байраар хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гаргасан санаачилгыг дэмжих; 12.2.Энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.4, 12.1.5-д заасан үйл ажиллагааг залуучуудын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.
----	---	------------	--

7.	Засгийн газрын тусгай сангийн тухай	2019-11-13	3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 3.2.Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, Улсын авто замын сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг тусгай хуулиар, нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна. 5 дугаар зүйл.Тусгай сан, түүний төрөл, тусгай санг шинээр байгуулах, татан буулгах 5.3.Тусгай сан дараах төрөлтэй байна: 5.3.12.Нийгмийн халамжийн сан;
8.	Зөрчлийн тухай хууль		5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 2.Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 3.Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих 5.Сургууль, сургуулийн дотуур байр, өдөр өнжүүлэх төв, асрамж, халамжийн төв, хүүхэд хамгааллын төв болон хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллага нь хүүхдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх үүргээ биелүүлээгүйгээс хүүхдийн эрх зөрчигдсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
9.	Коронавируст халдвар / ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай	2020.4.29	7 дугаар зүйл.Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ 7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 7.1.12.цар тахлын үед орон тэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулах;
10.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний Мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай	2019-05-30	1 дүгээр зүйл.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай: 9 Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 756.6 817.1 882.5 -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2020 2021 2022 1.9 1.8 1.7

11.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	2006.12.15	28 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх 28.1.Баг, хорооны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 28.1.6.шаардлагатай иргэдийг асрамжийн болон халамжийн үйлчилгээнд хамруулах саналыг хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх; 28.1.7.нутаг дэвсгэрийн хүн амын амьжиргааны түвшинг судлах; 29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх 29.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 29.1.5.хүн амын нийгэм-соёлын үйлчилгээ, нийгмийн хамгааллын талаар: д/нутаг дэвсгэрийнхээ хүн амын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг боловсруулж Хурлаар шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн зэрэг хууль тогтоомжид заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах ажлыг ерөнхий удирдлагаар хангах;												
12.	Монгол Улсын Засгийн газрын тухай	1993-05-06	9 дүгээр зүйл.Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгаалалтын талаархи Засгийн газрын бүрэн эрх 4.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ. Хууль тогтоомжид заасны дагуу хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажилд улс, олон нийтийн байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулна. 5.Хүн амын бодлого, түүний дотор хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудын талаар төрөөс явуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. 6.Ажил эрхлэлт, мэргэжлийн сургалт, хөдөлмөрийн асуудлаар оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх, иргэдийн хөдөлмөр, ахуй, орон сууцны нөхцөлийг сайжруулах, хэрэглэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авна. 7.Гэр бүлийг бэхжүүлэх, нийгмийн халамж, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, эх нялхас, тахир дутуу хүмүүс зэрэг нийгмийн эмзэг хэсгийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авна. 20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүн 8/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд: -хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал; -нийгмийн халамжийн бодлого;												
13.	Монгол Улсын Их хурлын тухай		20 дугаар зүйл. Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ 20.3. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо: 20.3.1. хүн ам, хөгжлийн бодлого; 20.3.3. нийгмийн халамж, хамгааллын бодлого;												
14.	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай	2019.11.13	3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай: <table><tr><td>17</td><td>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</td><td>53,133.2</td></tr><tr><td></td><td>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар</td><td>950.0</td></tr><tr><td></td><td>Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого</td><td>7 9 8 . 4</td></tr><tr><td></td><td>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого</td><td>51,384.8</td></tr></table>	17	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	53,133.2		Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	950.0		Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	7 9 8 . 4		Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	51,384.8
17	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	53,133.2													
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	950.0													
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	7 9 8 . 4													
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	51,384.8													

15.	Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай	2016.1.7	6 дугаар зүйл. Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго, чиг үүрэг 6.2.Энэ хуулийн 6.1-д заасан зорилгыг биелүүлэхийн тулд Монголын улаан загалмай нийгэмлэгийн дүрэм, Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар хөдөлгөөний олон улсын чуулганы тогтоолд тодорхойлогдсон дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 6.2.4.сайн дурын үйл ажиллагааг дэмжих, зэвсэгт мөргөлдөөн, гамшиг болон бусад хүчирхийлэлд өртсөн нэн эмзэг бүлгийн хүмүүст халамж үйлчилгээ үзүүлэх, амьжиргаа, амьдралын чанарыг дээшлүүлэхэд төрд нэмэлт хүч болон ажиллах; 6.3.Монголын улаан загалмай нийгэмлэг нь зорилго, чиг үүрэгтээ хамаарах дараах үйл ажиллагааг эрхэлнэ: 6.3.4.олон нийтийн оролцоонд түшиглэж нийгмийн эмзэг бүлэгт халамжийн үйлчилгээ үзүүлэх;
16.	Монгол Улсын Үндсэн хууль	1992.1.13	Тавдугаар зүйл. 4.Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна. Арван зургадугаар зүйл. Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: Арван есдүгээр зүйл. 1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.
17.	Нийгмийн халамжийн тухай хууль	2012.1.19	20.2.Боловсролыг дэмжих үйлчилгээнд дараах иргэнийг хамруулна: 20.2.4.гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэний хүүхэд; 22.1.Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд дараах өрхийн гишүүн-иргэн, иргэнийг хамруулна: 22.1.2.гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн.
18.	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай	2013.1.3	ХОЁРДУГААР БҮЛЭГ СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ДЭМЖИХ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ 5 дугаар зүйл.Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаарх төрийн байгууллагын үүрэг 5.1.Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар төрийн бүх шатны байгууллага тус тусын эрх хэмжээний хүрээнд дараах үүрэг хүлээнэ: 5.1.4.сэтгэцийн эмгэгтэй хүний хэрэгцээ, чадамжийг харгалзан мэргэжлийн сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, гэр бүл, орон нутагт нь ойр байлгаж, амьдрах ур чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээнд шаардлагатай төхөөрөмж, хэрэгслээр хангах, нийгмийн халамжийн болон боловсролын тусгайлсан үйлчилгээг бий болгох зэргээр тэдний бие даан амьдрах чадвар, нийгмийн амьдралд оролцох оролцоог нь дээшлүүлэх арга хэмжээ авах; 5.1.5.хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ нь тогтоогдоогүй, иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүнийг асран халамжлах асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэх; 6 дугаар зүйл.Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаарх иргэн, хуулийн этгээдийн үүрэг 6.1.Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ: 6.1.2.иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүний хууль ёсны төлөөлөгчид дэмжлэг, тусалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах. 6.2.Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих талаар Монгол Улсын иргэн дараах үүрэг хүлээнэ: 6.2.3.сэтгэцийн эмгэгтэй хүний бие даан амьдрах, нийгмийн амьдралд оролцоход нь дэмжлэг, тусалцаа үзүүлэх.

			14 дүгээр зүйл.Сэтгэцийн эмгэгтэй хүнд үзүүлэх нийгмийн халамжийн тусламжаа 14.1.Мэргэжлийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн сэтгэцийн эмгэгтэй хүнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох, асрамж, үйлчилгээнд хамруулах асуудлыг эрх бүхий байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
19.	Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль	2018.11.15	3 дугаар зүйл.Албадан эмчлэх үндэслэл 3.1.Согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүн согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураараа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулна. 6 дугаар зүйл.Сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргах 6.1.Согтуурах, мансуурах донтой нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураараа эмчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулна. 9 дүгээр зүйл.Шүүх шийдвэр гаргах 9.7.Цагдаагийн алба хаагч албадан эмчлэх тухай шүүхийн шийдвэр гарсан талаар тухайн хүний гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүнд, хэрэв ганц бие хүн бол түүний оршин суугаа газрын нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагад ажлын таван өдрийн дотор мэдэгдэнэ. 19 дүгээр зүйл.Сургалтад хамруулах 19.1.Албадан эмчлэх эмнэлэг эзэмшсэн мэргэжилгүй, ажил эрхэлдэггүй эмчлүүлэгчдэд зориулж мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулж болно. 19.2.Энэ хуулийн 19.1-д заасан сургалтыг дараах шаардлагын дагуу явуулна: 19.2.1.эмчлүүлэгчийн эмчилгээний горим, үр дүн, биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх; 19.2.2.сургалтын үргэлжлэх хугацаа эмчлүүлэгчийн эмчилгээний хугацаанд багтсан байх; 19.2.3.сургалтын үр дүнд мэргэжлийн үнэмлэх олгох; 19.2.4.сургалт явуулах байгууллага Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан шаардлагыг хангасан байх; 19.2.5.сургалт явуулах байгууллага Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нийцсэн үйлчилгээ, арга хэмжээг санал болгох. 19.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11.2, 11.4-т заасны дагуу сургалтын төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийн сангаас санхүүжүүлнэ. 19.4.Албадан эмчлэх эмнэлэг эмчилгээний хугацаа дууссаны дараа сургалтад хамрагдсан хүнийг эзэмшсэн мэргэжлийнх нь дагуу ажлын байранд зуучлах ажлыг хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагатай хамтран зохион байгуулж болно.
20.	Сургуулийн өмнөх боловсролын тухай	2008-05-23	8 дугаар зүйл. Цэцэрлэг 8.1.Цэцэрлэг нь ердийн, тусгай, сувиллын, асрамжийн, халамжийн гэсэн хэв шинжтэй байна. 8.6.Тусгай, гэр цэцэрлэг болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, асрамжийн болон халамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална
21.	Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/	2019.3.22	61 дүгээр зүйл.Битүүмжлэхийг хориглох хөрөнгө, орлого 61.1.Дараах хөрөнгийг битүүмжлэхийг хориглоно: 61.1.7.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээний хүрээнд олгосон тусламж, дэмжлэг.

22.	Төсвийн тухай /Шинэчилсэн найруулга/	2011.12.23	41 дүгээр зүйл.Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах 41.2.6.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх; 41.4.2.нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг доод хэмжээгээр нь; 58 дугаар зүйл.Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг 58.2.Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ: 58.2.4.нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах; 58.3.Дүүрэг өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ: 58.3.2.дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах; 58.4.Сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ: 58.4.2.сумын Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах;
23.	Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай	2013.7.5	7.1.Төлбөрийн чадваргүй яллагдагчид гэмт хэрэгт холбогдсон дараах хүн хамаарна: 7.1.1.Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн; 7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо тодорхойлсон хүн;
24.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	2016.02.05.	5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим 5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараахь зарчмыг баримтална: 5.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих; 5.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх; 5.1.3.сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх; 5.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх; 5.1.5.хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх; 5.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах. 26 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт 26.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж болно. Бусад холбогдох заалт

25.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /Шинэчилсэн найруулга/	2011-06-17	4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим, төрийн бодлогын чиглэл 4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчим баримтална: 4.1.4.ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөрлөх тэгш эрх, адил боломжийг хангах; 4.1.5.нийгмийн түншлэлийг дэмжих; 4.1.6.олон нийтийн оролцоонд тулгуурлах.
26.	Цагдаагийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/	2017.2.9	46 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох 46.6.1.хамгаалах боломжтой хүн, гэр бүлд хүлээлгэн өгөх; 46.6.2.нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, эсхүл асрамж, халамжийн үйлчилгээний байгууллагад хүргэх. 65 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны үүрэг, туслалцаа 65.2.Иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан дараахь чиглэлээр цагдаагийн байгууллагад туслалцаа үзүүлнэ: 65.2.6.төрийн болон төрийн бус байгууллага цагдаагийн байгууллагаас шаардсан мэдээллийг саадгүй гаргаж өгөх;
27.	Хүүхдийн эрхийн тухай хууль	2016.02.05.	13 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, оролцоо 13.1.Хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тэргүүлэх чиг үүргийг гүйцэтгэнэ: 13.1.5.хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг дэмжих; 16 дугаар зүйл. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл 16.4.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 16.4.1.хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах; 16.4.2.хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх.

28.	Хүүхэд хамгааллын тухай хууль	2016.02.05.	5 дугаар зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал 5.3.Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу үзүүлнэ. 6 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал 6.1.Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана. 6.2.Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлнэ. 6.3.Сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 6.3.1.сургалтын байгууллагын багш, ажилтан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмших; 6.3.2.сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх; 6.3.3.сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын хоорондын нөхөрсөг бус харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах; 6.3.4.хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх; 6.3.5.хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах. 7 дугаар зүйл. Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал 7.1.Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ. 7.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна. 7.3.Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ. 9 дүгээр зүйл. Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал 9.1.Худалдаа үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд ханган ажиллана. 10 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ 10.1.Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараахь хариу үйлчилгээ үзүүлнэ: 10.1.1.мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах; 10.1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх; 10.1.3.аюулгүй байдлыг хангах; 10.1.4.дэмжих, холбон зуучлах; 10.1.5.хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх; 10.1.6.гэр бүлд нь эргэн нэгтгэх.
-----	-------------------------------	-------------	--

			10.2.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ. 10.3.Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна. 10.4.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 13 дугаар зүйл. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах 13.1.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг харгалзан Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаас гадна хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах арга хэмжээг авна. 19 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтны хүүхэд хамгааллын чиглэлээр явуулах үйл ажиллагаа 19.1.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 19.1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, тэдний эрх ашгийг хамгаалах, хариу үйлчилгээнд хамруулах;
29.	Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай	1998-01-08	3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг; 3.1.2.хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг.
30.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай	2012-01-19	5.3.Хүн худалдаалахтай тэмцэх талаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.4.Хүн худалдаалахтай тэмцэх талаар нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.4.2.хохирогчийг хамгаалах, халамж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх. 5.12.Бүх шатны нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.12.2.хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; 12 дугаар зүйл.Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ 12.1.Хохирогчид дараах халамж, үйлчилгээг үзүүлнэ: 12.1.1.эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ; 12.1.2.сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ; 12.1.3.ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах; 12.1.4.хууль зүйн туслалцаа; 12.3.Энэ хуулийн 12.1-д заасан хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ үнэ төлбөргүй байна.
31.	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай	2017.6.30	1.1.Энэ хуулийн зорилт нь жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

32.	Эрүүгийн хууль	2015.12.03	7.4 дүгээр зүйл.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ 3.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно. 18.12 дугаар зүйл.Хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авах 1.Хуурамч баримт бичиг, эд зүйл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгож, бодит байдлыг нууж нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг авсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг зуун дөчин цагаас дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.албан тушаалын байдлаа ашиглаж; 2.2.их хэмжээний нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг авч үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Улсын Их Хурлын тогтоол			
1.	Коронавируст халдвар / COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай	2020-04-09 Дугаар 21	Дөрөв.Эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр: 2/эдийн засгийг төрөлжүүлэх, дэмжих, ажлын байр бий болгох, нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээг идэвхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, өх үүсвэр бүрдүүлэх гэрээ, хэлэлцээрийг байгуулах, түүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх;
2.	Нийгмийн халамжийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай	2009-11-25 Дугаар 81	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1.Төрөөс нийгмийн халамжийн талаар нэгдсэн бодлого баримтлах, халамжийн үйлчилгээг цэгцлэх, нэгтгэх арга хэмжээг дараахь чиглэлээр авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Батболд/-т үүрэг болгосугай: 3/нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, давхардлыг арилгах, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд бодитой нөлөө бүхий хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх, олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээг дэмжих, салбарын хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа нийгмийн халамжийн шинж чанартай олон төрлийн арга хэмжээ, хөтөлбөрийг нийгмийн халамжийн бодлогын эрх зүйн нэгдсэн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авах.

3.	Нийгмийн халамжийн тухай хуулиуд, Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	1995-12-19 Дугаар 89	Нийгмийн халамжийн тухай хуулиуд, Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1/Нийгмийн халамжийн тухай хуулиуд, Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиудад Засгийн газраас батлан мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, тэтгэмж, зардлын хэмжээг 1996 оны 4 дүгээр сарын 1-ний дотор батлан гаргах;
4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2017-06-09 Дугаар 46	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.
5.	Хүн амын нийгмийн хамгааллын талаар авах зарим арга хэмжээний тухай	1997-01-16 Дугаар 5	1.Хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай: 5/Нийгмийн халамжийн талаар төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагаа, нийгмийн халамжийн санг эрхлэн зохион байгуулахдаа ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилтай нягт уялдуулан зохицуулах.
Засгийн газрын тогтоол			
1.	Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай	2016-08-03 Дугаар 9	Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан хэрэгжүүлэгч агентлаг ажиллуулахаар тогтоосугай: -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар;
2.	“Ахмад насны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөр” батлах тухай,	2020.03.04 Дугаар 84	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.26-д “Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулахыг дэмжинэ” гэсэн бодлогын зорилтыг хангахад “Ахмад настны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөр” чиглэгдэх болно. Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим 2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална: 2.1.1. шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого болон нийгмийн халамжийн шинэчлэлийн бодлоготой нийцүүлж нийгмийн хамгааллын талаар авч хэрэгжүүлж байгаа салбарын стратегитэй уялдуулсан байх; 2.1.2. ахмад настны төрөлжсөн асрамжийн шинэчлэл хийхэд салбар дундын үйл ажиллагаа, харьяа байгууллагуудын ажлын уялдаа холбоо, оролцогч талууд, гадаад, дотоодын донор байгууллагуудын оролцоог бүрэн дүүрэн хангах; 2.1.3. төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлах, иргэд олон нийтийн оролцоог дэмжих, салбар дундын болон төв, орон нутгийн байгууллагын уялдааг хангах, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн таатай нөхцөлийг бий болгосон байх;

3.	Үндэсний хөтөлбөр батлах тухай /Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"	2019.10.30, Дугаар 389	ХАВСРАЛТ Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа 5.1. Ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 5.1.12. ахмад настны амьжиргааг дэмжих, ядуурлаас хамгаалах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх. 5.2. Ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих, урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 5.2.8. Гэрээр болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн хөдөлмөрийн үнэлэмж, нийгмийн хамгааллын асуудлыг судалж шийдвэрлэх; 5.2.9. ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг нэмэгдүүлэх, асаргаа, сувилгааны чиглэлээр сургалтад хамруулах, мэргэшүүлэх, тэдэнд зориулсан зөвлөгөө, дэмжлэг туслалцааг өргөжүүлэх; 5.2.11. түншлэл, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоонд түшиглэн өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох замаар ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний сүлжээ бий болгох;
4.	Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1. "Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай. Хавсралт Арван нэг. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт 11.1.2. нийгмийн хамгааллын үйлчилгээ, дэмжлэг туслалцаа зорилтот бүлгийн иргэдэд хүрсэн байна. 11.1.2-д заасан үр дүнгийн хүрээнд. а) в) Нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, болзлыг хангасан иргэд шаардлагатай үйлчилгээндээ бүрэн хамрагдсан байна.
5.	"Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай"	2014.4.26 дугаар 137	1. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг бүртгэлжүүлэн мэдээллийн сан бүрдүүлэх, нийгмийн халамж болон сэтгэл засал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байранд зуучлах зэрэг тэднийг нийгэмшүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвтөө тусган хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.	Аргачлал шинэчлэн батлах тухай /Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал/	2019.12.18 Дугаар 445	Орон нутгийн төсвийн суурь зарлагад тооцох нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний жагсаалт 2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 2.1. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах 2.2. Зөвлөгөө өгөх 2.3. Сэргээн засах үйлчилгээнд хамруулах 2.4. Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах 2.5. Өдрийн үйлчилгээнд хамруулах 2.6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах 2.7. Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх 2.8. Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах 2.9. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах 2.10. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах
7.	Өнчин, эцэг эхийн хараа хяналтаас гарсан хүүхдийн талаар авах зарим арга хэмжээний тухай	1997-09-22	Улсын Их Хурлын 1997 оны 52 дугаар тогтоолын 6 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь : 4.Өнчин, эцэг эхийн хараа хяналтаас гарсан болон нэн ядуу айл өрхийн хүүхдүүдийн амьдрал байдлыг сайжруулах зориулалтаар 1997 оны 2 дугаар хагаст 100 сая төгрөг, хэрвээ харж хандах хүнгүй хүүхдэд зориулсан халамж, үйлчилгээний төв байгуулан ажиллуулахад олон улсын халамжийн байгууллагуудаас хөрөнгө гаргахаар бол энэ арга хэмжээнд 50 сая төгрөг тус тус улсын төвлөрсөн төсвөөс гаргахыг Сангийн сайд П.Цагаан, уг хөрөнгийг үр ашигтай зарцуулж, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд Л.Зориг нарт тус тус даалгасугай.
8.	"Үндэсний хөтөлбөр батлах тухай"	2019.4.23 дугаар 159	1. "Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, "Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 26 дугаар хавсралт болгон 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. Хавсралт 1. 5.5.10. ядуурлын түвшингийн хамгийн доогуур хэрэглээтэй нэн ядуу иргэдэд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, туйлын ядуурлыг бууруулах;

9.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай)	2017.12.13 дугаар 340	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 5.1, 7.1, 7.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1.“Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. (Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2018 оны 96 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон) 2.Жирэмсэн эхийн тэтгэмжийн хэмжээг сард 40.000 (дөчин мянган) төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг сард 50.000 (тавин мянган) төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 1.000.000 (нэг сая) төгрөг, 3 болон түүнээс дээш ихэр хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг нэг удаа хүүхэд тус бүрт 3.000.000 (гурван сая) төгрөг байхаар тус тус тогтоосугай. 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 3.5, 4.7 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 136 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн сангаас олгох зарим тэтгэмж, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн хэмжээ”-ний 4, 5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай. 4.Энэ тогтоолыг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
Сайдын тушаал			
1.	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал, Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам	2017-04-06 Дугаар А/84/ А/59/ А/130	1.6.Хохирогчид хуульд заасан үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэхэд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/52 дугаар тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх журам”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/330 дугаар тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ын холбогдох заалтыг нийцүүлэн хэрэглэж болно.
2.	Эрүүл мэндийн сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал Жагсаалт, шалгуур үзүүлэлт, заавар, маягт батлах тухай	2018-02-23 Дугаар А/69, 48	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.“Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт”-ыг нэгдүгээр,”Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт”-ыг хоёрдугаар,”Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан,хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг гуравдугаар,”Байнгын асаргаа шаардлагатай иргэн хүүхдийг тодорхойлох заавар”-ыг дөрөвдүгээр, “Байнгын асаргаа шаардлагатай иргэн, хүүхдийн тодорхойлолт маягт”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Журам, загвар шинэчлэн батлах тухай / Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх/	2019-02-14 Дугаар А/65	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.9 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 7.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.“Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Магадлан итгэмжлэгдсэн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад олгох гэрчилгээний загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. Хавсралт бүхэлдээ хамаарна.
4.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Сургалт зохион байгуулах үйлчилгээний чанарт тавигдах шалгуур батлах тухай	2019.12.26 Дугаар 374	Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, 18.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний “Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээний чанарт тавигдах шалгуур”-ыг хавсралтаар баталсугай.
5.	Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам батлах тухай	2018-01-08 Дугаар 03/03	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.“Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай асрамжийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
6.	Эрүүл мэндийн сайдын тушаал, Сувилал, сэргээн засах болон сувилахуйн төвийг магадлан шинжлэх шалгуур батлах тухай,	2020.03.16 Дугаар А/180	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1.“Сувиллыг магадлан шинжлэх шалгуур”-ыг нэгдүгээр, “Сэргээн засах төвийг магадлан шинжлэх шалгуур”-ыг хоёрдугаар, “Сувилахуйн төвийг магадлан шинжлэх шалгуур”-ыг гуравдугаар, Сувилал, сэргээн засах болон сувилахуйн төвд магадлан шинжлэх шалгуураар үнэлгээ хийх аргачлалыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

7.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал, Журам батлах тухай / Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах/,	2018.10.01, Дугаар А/612	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг тус тусүндэслэн ТУШААХ нь: 1.“Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. Хоёр. Ерөнхий зохион байгуулалт 2.1. “Хамтарсан баг” нь нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хүчирхийлэлд өртсөн болон болзошгүй эрсдэлд байгаа насанд хүрээгүй хүүхдийг урьдчилан сэргийлж, түр хамгаалах байранд шилжүүлэн суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах, тэдний суралцах хэвийн нөхцөлийг хангах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Боловсрол, соёл, урлагийн газар, хэлтэс, Насан туршийн боловсролын төв, ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн дараах хэлбэрээр хамтран зохион байгуулна:
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор			
1.	“Гэртээ харих зам” хөтөлбөр ¹⁴²	2015.10.23 Дугаар 187	Төсөл, хөтөлбөрийн зорилго: Иргэдийг тэнэмэл амьдралд шилжихээс урьдчилан сэргийлэх, гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх замаар амьдралын чанарыг сайжруулах тухай
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаал,			
1.	Аргачлал батлах тухай,	2018.04.19, Дугаар А/80	

¹⁴² <http://development.ub.gov.mn/uploads/Gertee-xarix-zam.pdf>

Хавсралт 2

2019 оны 11-р сарын 1

№	Дүүрэг	Гэрээ байгуулсан огноо	д/д	Үйлчилгээний төрөл	Байгууллагын нэр	Удирдлагын нэр	Харилцах утас	Тайлбар
1	ХУД	06.06	1	Сургалт зохион байгуулах	"Бат-Өөдөө" ХХК	Б.Хишигжаргал	99023516	2019 онд магадлан авсан.
2		06.06	2	Зөвлөгөө өгөх	"Тэнүүн итгэлт үйлс"	М.Мөнхтогтох	99049779	2019 онд магадлан авсан.
3		06.06	3	Сэргээн засах	"Сайжив Оюу" ХХК	Я.Оюунцэцэг	96635778, 88830799	2019 онд магадлан авсан.
4		06.06	4	Сэргээн засах	Озон сервис" ХХК	Д.Нэмэхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
5		06.06	5	Сэргээн засах	"Батануан СТ" ХХК	П.Тогоо	96620371	2019 онд магадлан авсан.
6		06.06	6	Өдрийн үйлчилгээ	"Ачлалт Орчлон" ХХК	Ө.Сэргэлэн	95143005, 99824847	2018 онд магадлан авсан.
7		06.06	7	Өдрийн үйлчилгээ	"Монголын хараагүйчүүдийн холбоо" ТББ	Б.Болдбаатар	88111379	2018 онд магадлан авсан.
8		06.06	8	Гэрийн асрамж халамж	"Монголын мэдрэлийн сэргээн засахын үндэсний нийгэмлэг" НҮТББ	М.Бүрэнтөгс	99559257	2019 онд магадлан авсан.
9		06.06	9	Түр байрлуулан асрамжлах	"Өлзийт Асар" ТББ	Л.Баянмөнх	95244085	2018 онд магадлан авсан.
10		06.06	10	Түр хоноглох	"Хаган богда" ТББ	Б.Алтанбаяр	99088653, 99990796, 88014104	2018 онд магадлан авсан.
11	СХД	06.18	1	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	"Амар тал" ХХК	Д.Алтанцэцэг	99063019	2019 онд магадлан авсан.
12		06.18	2	Сэргээн засах	"Ачит арвис" ХХК	Я.Сараңчимэг	98100009	2019 онд магадлан авсан.
13		10.01	3	Сэргээн засах	"Озон сервис" ХХК	Д.Нэмэхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
14		10.01	4	Сэргээн засах	"Хас цэгц" ХХК	Д.Цэцэгсүрэн	99004881	2019 онд магадлан авсан.
15		10.01	5	Сэргээн засах үйлчилгээ	"Ариун лотус" ХХК	Л.Хандсүрэн	88828287	Тодорхой биш
16		06.18	6	Өдрийн үйлчилгээ	"Наянзургаа дөрвөн зуу" ХХК	П.Чинбат	95731260	2019 онд магадлан авсан.
17		06.18	7	Гэрийн асрамж халамж	"Ачлалт хүүхдүүд" ТББ	Я.Болор	94049098	2018 онд магадлан авсан.
18		06.18	8	Түр байрлуулан асрамжлах	"Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" ТББ	Н.Араинтэриа	99204558	2019 онд магадлан авсан.
19		06.18	9	Түр хоноглох	"Титэм констракшн" ХХК			2018 онд магадлан авсан.

20	БХД	06.19	1	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ, түр байрлуулан халамжийн үйлчилгээ	"Хангайн хаш чулуу" ТББ	Д.Боломж	99979406	2019 онд магадлан авсан.
21	БХД	06.19	2	Гэрийн асрамж халамж	Багахангай "Улаанзагалмайн хороо" ТББ	Н.Зина	99047472	2018 онд магадлан авсан.
22		07.02	3	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	"Монголын эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэг" ТББ	Ж.Сугар	98989993	2018 оны 10 сард магадлан авсан
23		07.02	4	Сургалт зохион байгуулах	"Насжилт судлал, настны эмгэг судлалын нийгэмлэг" ТББ	Т.Дулмаа	99756838	2019 онд магадлан авсан.
24		07.01	1	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ,	"Тулгат-МТМ" ХХК	Д. Тунгалаг	99182367	2017 онд магадлан авсан.
25	БЗД	07.01	2	Өдрийн үйлчилгээ	"Сэтгэл зүйн эрүүл оршихуй" ТББ	Р.Уянга	99250118	2019 онд магадлан авсан.
26		07.01	3	Түр байрлуулан асрамжлах	"Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" ТББ	Н.Арвинтэриа	99204558	2019 онд магадлан авсан.
27		07.01	4	Түр хоноглох	"Дөлгөөн минж" ТББ	Т.Хатанбаатар	94117546	2018 онд магадлан авсан.
28		07.01	5	Түр хоноглох	"Шинэ амьдрал ялагч" ТББ	А.Батцэнгэл	96328858	2018 онд магадлан авсан.
29		07.25	6	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	"Сэтгэл зүйн сургалт, хөдөлгөөнт дасгалын төв" ТББ	Д.Оюунчимэг	91914375	2019 онд магадлан авсан.
30		07.25	7	Сургалт зохион байгуулах	"Шинэ хөгжлийн тулхуур" ТББ	Б. Анхбаяр	99176180	2018 онд магадлан авсан.
31		07.25	8	Зөвлөгөө өгөх	"Хойморын эзэд" ТББ	Б.Мэндбаяр	90242744	2018 онд магадлан авсан.
32		09.05	9	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	"Амьдрах увидас" ХХК	Б.Энхсайхан	88050358	2019 онд магадлан авсан.
33		09.05	10	Түр хоноглох	"Зөв амьдрах ухаан" ТББ	Г.Загдаа	99938959	2018 онд магадлан авсан.
34		09.05	11	Сэргээн засах	"Озон сервис" ХХК	Д.Нөмхөхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
35	БЗД	09.05	12	Сэргээн засах	"Есүн-Удам" ХХК	Б.Идэрмөнх	99026628	2018 онд магадлан авсан.
36		09.05	13	Сэргээн засах	"Дут баян богд" ХХК	Ц.Пэлжидмаа	99215097	2018 онд магадлан авсан.

37		08.19	1	Сургалт зохион байгуулах	"Насжилт судлал, настны судлалын нийгэмлэг" ТББ	Т.Дулмаа	99756838	2019 онд магадлан авсан.
38		08.19	2	Сэргээн засах	"Озон сервис" ХХК	Д.Нэмэхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
39		08.19	3	Сургалт, зөвлөгөө өгөх	"Хойморын зээд" ТББ	Б.Мэндбаяр	90242744	ЧД авах
39		08.19	4	Өдрийн үйлчилгээ	"МББ жаргалан" ХХК	Д.Оюунчулуун	96001672	2018 онд магадлан авсан.
40		08.19	5	Сэргээн засах үйлчилгээ	"Батануган" ХХК	П.Тогоо	96620371	2019 онд магадлан авсан.
41		08.19	6	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	"Ахмадын мишээл" ТББ	Д.Оюунсүрэн	99132907	2019 онд магадлан авсан.
42		08.19	7	Түр байршуулан асрамжлах	"Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" ТББ	Б.Сувд	70119949, 88441944	2019 онд магадлан авсан.
43		08.19	8	Түр хоноглох	"Тэрэм Уул" ХХК	Г.Эрдэнэбат	96601757,	2018 онд магадлан авсан.
44		10.01	9	Сэргээн засах	"Нейрожелт" ХХК	Б.Рэгээдмаа	91013052	2018 онд магадлан авсан.
45		09.04	1	Сургалт зохион байгуулах	"Хайрхан бүрд" ТББ	Р.Нямжав	99059257	2017 онд магадлан авсан.
46		09.04	2	Зөвлөгөө өгөх	"Тэнүүн итгэлт үйлс" НУТББ	М.Мөнхтогтох	99076577	2018 онд магадлан авсан.
47		09.04	3	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	"Очир дэлэг" ХХК	Г.Ганзориг	88313533, 99030545	2018 онд магадлан авсан.
48		09.04	4	Сэргээн засах үйлчилгээ	"Эй ви жи" ХХК	О.Бат-Эрдэнэ	99177347	2019 онд магадлан авсан.
49		09.04	5	Сэргээн засах үйлчилгээ	"Пиксел" ХХК	Б.Содбилэг	88011045	2018 онд магадлан авсан.
50		09.04	6	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	"Гурван цохиот" ХХК	А.Дариймаа	99050649	2018 онд магадлан авсан.
51		09.04	7	Өдрийн үйлчилгээ	"Монголын хараагүйчүүдийн холбоо" ТББ	Б.Болдбаатар	88111379	2018 онд магадлан авсан.
52		09.04	8	Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ	"Түгээмэл хөгжил" ТББ	Ч.Ундрахбаяр	99267408, 99856665	2018 онд магадлан авсан.
53		09.04	9	Түр байршуулан асрамжлах	"Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" ТББ	Б.Сувд	70119949, 88441944	2019 онд магадлан авсан.

54		09.09	1	Зөвлөгөө өгөх	"Нийгмийн даатгалын мэдээллийн холбоо" ТББ	Р.Наранцэцэг	88002766, 99118085	2019 онд магадлан авсан.
55		09.09	2	Сэргээн засах	"Озон сервис" ХХК	Д.Нэмэхбат	91929285, 91909075	2019 онд магадлан авсан.
56	СБД	09.09	3	Сэргээн засах	"Ачит арвис" ХХК	Я.Саранчимэг	98100009	2019 онд магадлан авсан.
57		09.09	4	Сэргээн засах	"Хаш чулуун энхийн цэцэг" ХХК	Ж.Энхцэцэг	99008471, 99682040	2019 онд магадлан авсан.
58		09.09	5	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ,	"Тулгат МТМ" ХХК	Д.Тунгалаг	99182367	2017 онд магадлан авсан.
59		09.09	6	Түр байршуулан асрамжлах	"Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" ТББ	Б.Сувд	70119949, 88441944	2019 онд магадлан авсан.
60	НД	08.20	1	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	"Цэглэмт ухаан нандин хүсэл" ТББ	А.Хүслэн	91860120	2018 онд магадлан авсан.
61		08.20	2	Сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	"Өүлэн эхийн ачлал" ХХК	П.Эрдэнэтөгтох		2019 онд магадлан авсан.
62		08.20	3	Сэргээн засах, өдрийн үйлчилгээ	"Си си мэд" ХХК	Г.Сувдаа	80478074	2019 онд магадлан авсан.
63		10.23	1	Сургалт зохион байгуулах	"Азийн нөхөрлөл" ТББ	Д.Номуунзаяа	99152277	2018 онд магадлан авсан.
64	БНД	10.23	2	Сэргээн засах үйлчилгээ үзүүлэх	"Замбага трейд" ХХК	М.Шүрэнцэцэг	99286194	2019 онд магадлан авсан.
65		10.23	3	Гэрийн асрамж халамж, өдрийн үйлчилгээ	Багануур дүүргийн "Улаан загалмай хороо" ТББ	Л.Хонгорзул	94079798	2018 онд магадлан авсан.
66		10.23	4	Өдрийн үйлчилгээ	"Ахмадын хороо ТББ"	Ж.Мядаг	99127031	2018 онд магадлан авсан.

д/д	Хууль, журмын заалт	Үйлчилгээний төрөл	Нэмэлт мэдээлэл, хэрэгжүүлэх аргачлал
1	НХТ Хууль 18.1.1	Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;	Үйлчилгээний чиглэл: 1. Амьдрах ухааны болон бие даан амьдрах ур чадвар эзэмшүүлэх; 2. Хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах; 3. Амьдралын итгэл үнэмшил бий болгох сургалт зохион байгуулах; Үйлчилгээний хэлбэр: 1. Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх үнэлэмж бий болгох; 2. Зорилтот бүлгийн гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулах; 3. Өдөр тутмын амьдралын дарамт, стрессийг даван туулах чадварыг бий болгох; 4. Эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх; 5. Тодорхой бэрхшээл, эрсдлээс зайлсхийх, даван туулах, урьдчилан сэргийлэх чадварыг бий болгох; 6. Мэргэжлийн чиг баримжаа олгох Хамрагдах өрх, иргэн: 1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; 8. Өрх толгойлсон эх /эцэг/;
2	НХТ Хууль 18.1.2	Зөвлөгөө өгөх;	Үйлчилгээний чиглэл: 1. Хууль зүйн зөвлөгөө өгөх; 2. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх; Үйлчилгээний хэлбэр 1. Амьдралын асуудлаа өөрсдөө шийдвэрлэхэд туслах; 2. Тулгарч буй сэтгэл зүйн асуудал, бэрхшээлтэй нөхцөл байдлыг оношлон тогтоох, шийдвэрлэхэд нь мэргэжлийн тусламж, дэмжлэг үзүүлэх; Хамрагдах өрх, иргэн: 1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; 8. Өрх толгойлсон эх /эцэг/; 9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн
3	НХТ Хууль 18.1.3	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	Үйлчилгээний чиглэл: 1. Эрүүл мэндийн сэргээн засах; 2. Боловсролын сэргээн засах; 3. Хөдөлмөрийн сэргээн засах; 4. Нийгэм-сэтгэл зүйн сэргээн засах; Үйлчилгээний хэлбэр: 1. Хэл, хөдөлгөөн, ахуйн, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх; 2. Эзэмшсэн мэргэжлийг нь сэргээх, ур чадварыг нь сайжруулах; 3. Алдагдсан чадварыг сэргээхэд чиглэсэн орчныг бүрдүүлэх, сэтгэл зүйн нөлөөллийг үзүүлэх;

			4. Нийгмийн зан үйл, нөлөөллийн аргуудыг ашиглах замаар хүмүүсийн харилцааны боломжит нөхцөлийг бүрдүүлэх; 5.Боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх, ахуйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай байгууллагын үйл ажиллагаанд хамруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал хийх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх; Хамрагдах өрх, иргэн: 1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; 8.Өрх толгойлсон эх /эцэг/; 9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн Тайлбар: Сэргээн засах үйлчилгээ нь хүний алдагдсан эрүүл мэнд, хөдөлмөрлөж аж төрөх чадварыг сэргээж, нийгмийн болон хувийн амьдралд нь идэвхитэй оролцох боломж нөхцлийг нь бүрдүүлэхэд нийгэм анагаах ухаан, хөдөлмөр сургалт сэтгэл зүйн цогц үйлчилгээ.
4	НХТ Хууль 18.1.4	Түр байрлуулан асрамжлах	Үйлчилгээний чиглэл: 1. Хүчирхийлэлд өртөх магадлалтай иргэдийг урьдчилан сэргийлэх; 2. Хүчирхийлэлд өртсөн иргэдэд стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх; Үйлчилгээний төрөл: 1. Бичиг баримтжуулах, 2. Эрүүл мэндийн болон хууль зүйн үйлчилгээ үзүүлэх; 3. Хөгжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, 4. Холбон зуучлах; 5. Хүүхдэд бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх; 6. Халуун хоол цайгаар үйлчлэх; Хамрагдах өрх, иргэн: 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 2. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 3. Хорих ангиас суллагдсан иргэн; 4.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 5. Шилжин суурьшсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн гишүүн -иргэн; 6. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд; Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ: Хохирогчийг хүлээн авснаас эхлэн 1 долоо хоногоос 3 сар хүртэлх хугацаанд тусламж үйлчилгээ үзүүлнэ. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсхүл хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулж хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэхүй нь түр хямарсан үед эмчилгээ хийх сэргээн засах зэрэг үйлчилгээ үзүүлнэ.

5	НХТ Хууль 18.1.5	Өдрийн үйлчилгээ	Үйлчилгээний чиглэл: 1. Ахмад настны өдрийн үйлчилгээ үзүүлэх; 2. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн өдрийн үйлчилгээ үзүүлэх; 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдрийн үйлчилгээ үзүүлэх; 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний өдрийн үйлчилгээ үзүүлэх; Үйлчилгээний хэлбэр: 1. Соёл, урлаг биеийн тамир спортын арга хэмжээнд оролцуулах; 2. Сэргээн засах; 3. Амьдрах ухаанд сургах; 4. Зөвлөгөө өгөх; Хамрагдах өрх, иргэн: 1. Ахмад настан; 2. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд; 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хүүхэд Өдрийн үйлчилгээ: Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээ
6	НХТ Хууль 18.1.6	Гэрийн асрамж, х а л а м ж и й н үйлчилгээ	Үйлчилгээний хэлбэр: 1. Гэр ахуйн үйлчилгээ үзүүлэх; 2. Өдөр тутмын асаргааны үйлчилгээ үзүүлэх; 3. Гадуур ажилд туслах үйлчилгээ үзүүлэх; 4. Эрүүл мэнд, эмчилгээний дэглэм сахиулах; 5. Хоол хүнс бэлтгэх, хоолны дэглэм сахиулах, хооллож ундлах; Хамрагдах өрх, иргэн: 1. Байнгын асаргаатай ахмад настан; 2. Байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд;
7	НХТ Хууль 18.1.7	Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд ту л г у у р л а с а н н и й г м и й н халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;	Үйлчилгээний чиглэл: 1. Өрх, иргэний амьдралын нөхцөл байдлыг өөрсдийнх нь оролцоотойгоор үнэлэх; 2. Өрх, иргэний нөөц боломж чадавхи хэрэгцээнд тохирох үйлчилгээг туршин хэрэгжүүлэх; Үйлчилгээний хэлбэр: 1. Өөрсдөө бие даан хөгжих боломжийг нь судалж, 2. Өрхийн нөхцөл байдлыг судлан үнэлэх, нөөц боломж, чадавхийг тодорхойлж, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн болон хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх. Хамрагдах өрх, иргэн: 1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн -иргэн; 8. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн; 9. Өрх толгойлсон эх /эцэг/; Аргачлал: Өөрсдөө бие даан хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал, нийгмийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн нөхцөл байдлыг судлан үнэлэх, нөөц боломж, чадавхи, хэрэгцээг өрхийн гишүүдийн оролцоотой тодорхойлж, өрхийн гишүүдийг сэтгэл зүйн хувьд сэргээн засах, нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээг үзүүлнэ.

8	НХТ Хууль 18.1.9	Н и й г м и й н х а л а м ж и й н дэмжлэг, туслалцаа з а й л ш г ү й шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.	Үйлчилгээний чиглэл: 1. Төсөл бичих, түүнийг хэрэгжүүлэх амьдрах ухааны сургалтанд хамруулах, зөвлөгөө өгөх 2. Хамт олны бүлэг бүрдүүлж орлого нэмэгдүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх, нийгэмшүүлэх Үйлчилгээний хэлбэр: 1. Төсөл бичих чадвартай болгох; 2. Багаар ажиллах чадвартай болгох. 3. Тухайн төслөө хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвартай болгох; 4. Тухайн төслийг цааш нь өргөжүүлэх санхүүгийн эх үүсвэртэй болох; Хамрагдах өрх, иргэн: 1. Ахмад настан; 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 3. Хүчирхийлэлд өртсөн иргэн; 4. Хорих ангиас суллагдсан иргэн; 5. Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн; 6. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн; 7. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн; 8. Өрх толгойлсон эх /эцэг/; 9. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэн Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2 ба түүнээс дээш өрх, иргэд өөрсдийн санаачлагаар нэгдэн бүлэг болж орлогоо нэмэгдүүлэх зорилгоор төсөл боловсруулан хэрэгжүүлэх нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэг төрөлд хамрагдана. Иргэдийн ирүүлсэн төслийг амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. АДЗ-өөр дэмжигдсэн төслийг НХҮХ хянаж үзээд хэрэгжих магадлалтай бол 1,0 сая хүртэлх төгрөгөөр санхүүжүүлнэ.
---	---------------------	--	--

(Footnotes)

1 Дэлгэрэнгүйг харилцан уялдаа хэсгийн “Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх” хэсгээс үзнэ үү.

2 Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг үнэлсэн хэсгээс үзнэ үү.

3 ХЗДХ сайдын 2017.2.14-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”-ыг баримжаалав.

4 Бүртгэлийн гэрчилгээ олгохоос эхлээд улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа авах хүртэлх үйлчилгээ багтах юм.

5 Нэг байршлаас нөгөө байршил руу ирэх, очих хугацаа, замын хөдөлгөөний нягтаршил зэргийг харгалзан дээд хугацаагаар тооцов.

6 Энэ нь анхан шатны зөвлөгөө өгөх хугацаа бөгөөд сэтгэл заслын эмчилгээ 2 жил хүртэл хугацаагаар үргэлжилдэг байна.

7 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс.

8 Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгалд хамаарах бөгөөд хангамж, бараа материалын зардлын нэг хэсэг болдог байна.

9 Нэг ширхэг автомашинд ногдох зардал.

10 МУЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоол “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”.

11 Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Үнийг дунджаар 800,000₮ гэж тооцоход 20% нь элэгдэл, хорогдол буюу 160,000₮ болно.

12 Мөн тэнд – Хоёрдугаар хавсралт, Эд хогшил болох ширээ, сандал, шүүгээ, утасны аппаратын үнийг дунджаар 1,000,000₮ гэж тооцоход 10% нь элэгдэл хорогдол буюу 100,000₮ болно.

13 ЗГ-ын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг

жишиг”-т заасны дагуу нэг дэс түшмэлд ногдох ажлын өрөөний талбай 8м2 талбай байна. Үүнээс 2,300,000,000₮ 4483м2 = 513,049.29₮ нь 1м2 талбайн өртөг бөгөөд 8м2 талбайн өртөг нь 4,104,394.37₮ болно. Нэг албан хаагчид оногдох талбайн өртөг 4,104,394.37₮ гэж тооцоход 1,6% нь элэгдэл хорогдол буюу 65,670₮ болно.

14 Мөн тэнд. Түр хамгаалах байрны 1 хоногийн зардалд “Цалин, шимтгэл” гэдгийг нэгтгэн “цэвэрлэгээ, үйлчилгээний хөлс” гэж өөрчилсөн ба нийт үнийн дүнд өөрчлөлт ороогүй болно. /ажилтны цалин хөлсийг хүний нөөцийн зардалд тооцсон тул энд давхардуулан тооцох шаардлагагүй гэж үзлээ./

15 “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2009 Монгол Улсын стандартад зааснаар “Түр хамгаалах байр” гэж хохирогчийг хүлээн авснаас эхлэн 1 долоо хоногоос 3 сар хүртэлх хугацаанд тусламж, үйлчилгээ үзүүлэх газрыг хэлэх бөгөөд нийт зардлыг тооцохдоо дээд хугацаа болох 3 сар буюу 90 хоногийн хугацаагаар тооцов. Ингэхдээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/80 дугаар тушаалын хавсралтаар баталсан нэг хоногийн зардлыг 90 хоногоор үржүүлэн нийт дүнг гаргасан.

16 А/80 дугаар тушаалын хавсралтад бичиг баримттай холбоотой үйлчилгээний зардлыг тусгаснаас нийт дүнг авав.

17 Мөн тэнд. Нэг үйлчлүүлэгчид шаардлагатай уламжлалт болон орчин үеийн аргаар сэргээн засах үйлчилгээний дүнг нэгтгэн гаргасан.

18 <https://medee.mn/single/147218> сүүлд үзсэн 2020.5.25

19 Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан <https://updown.mn/104555.html> Сүүлд үзсэн 2020.5.25

20 Г.Загдаа эмзэг бүлгийн иргэдийн 600 гаруй саяыг завшжээ. <https://www.urug.mn/news/1048>

21 БЗД-ийн хяналтын албаны мэргэжилтэн Ч.Гүндсамбуу /ярилцлагын хэсгээс/

22 Баянзүрх дүүргийн халамжийн албаны дарга Ш.Ганцэцэг /ярилцлагаас/

23 <http://development.up.gov.mn/uploads/Gertee-xarix-zam.pdf>